

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар: 12

Улаанбаатар хот

**Төлөвлөгөө шинэчлэн
батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2, 21.2.9 дэх хэсэг, Даатгалын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2022-2026 оны бизнес төлөвлөгөө-г хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тогтоолыг 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

ҮНДЭСНИЙ ДАВХАР
ДААТГАЛ ХК

Mongolian Re

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛ

“Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн
12 дугаар тогтоолын ХАВСРАЛТ

1116962 5895512

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ 2022-2026

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
I. УДИРТГАЛ	7
II. ГАДААД, ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	7
2.1. ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	7
2.2. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	10
2.3. ОЛОН УЛСЫН ДАВХАР ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА.....	11
2.4. ДОТООДЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	14
2.5. ДОТООДЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ.....	18
III. ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	20
3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	20
3.2. СВӨТ ШИНЖИЛГЭЭ.....	21
IV. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД.....	23
4.1. НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ.....	23
4.1.1. Зорилт 1 - Компанийн санхүүгийн чадавхын олон улсын үнэлгээ тогтоолгох.....	23
4.1.2. Зорилт 2 - Компанийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх	23
4.1.3. Зорилт 3 – Компаенсийн хэрэгжилтийг хангах.....	24
4.1.4. Зорилт 4 – Сайн засаглалын бүтэц, чиг үүргийг хэрэгжүүлэх.....	25
4.1.5. Зорилт 5 – Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх	25
4.1.6. Зорилт 6 - Нийгмийн хариуцлагатай компани байх	25
4.2. ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРЛИЙГ ОЛШРУУЛЖ, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ.....	26
4.2.1. Зорилт 1 - Даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ	26
4.2.2. Зорилт 2 – Олон улсын байгууллагын зээлийн андеррайтинг хийх.....	27
4.2.3. Зорилт 3 – Олон улсын зах зээлд давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх.....	27
4.2.4. Зорилт 4 – Гамшгийн бонд гаргах, удирдах	27
4.3. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ.....	28
4.3.1. Зорилт 1 – Гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	28
4.3.2. Зорилт 2 - Дотоод хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	28
4.4. ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ӨГӨГДЛИЙН САНТАЙ БОЛОХ.....	29
4.5. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ	30
V. ДААТГАЛЫН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ.....	30
5.1. АШГИЙН ЗОРИЛТ	30

5.2.	МАЛ АМЬТДЫН ДААТГАЛЫН ХЭЛБЭР	32
5.3.	ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ХЭЛБЭР	34
5.4.	ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ.....	35
5.5.	ФАКУЛЬТАТИВ ДАВХАР ДААТГАЛ.....	36
5.6.	ГЭРЭЭТ /ТРИТИ/ ДАВХАР ДААТГАЛ	37
VI.	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	38
6.1.	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИЛГО, УДИРДЛАГА	38
6.2.	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2022-2026 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ	39
VII.	САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ	41
VIII.	МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	43
IX.	МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	46
9.1.	КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	46
9.2.	ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	49
X.	ДҮГНЭЛТ	50
Хавсралт 1.	Компани санхүүгийн чадавхын олон улсын үнэлгээ тогтоолгох.....	51
Хавсралт 2.	Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ	53
Хавсралт 3.	Гамшгийн бондын тухай.....	57
Хавсралт 4.	Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө.....	- 1 -

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДДХЗ	Давхар даатгалын хураамжийн зардал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЖДХ	Жигнэсэн дундаж хүү
МИД	Малын индексжүүлсэн даатгал
МИДТ	Малын индексжүүлсэн даатгал төсөл
МДХ	Монголын даатгалын холбоо
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
МХАҮТ	Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим
МХБ	Монголын хөрөнгийн бирж
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУВС	Олон Улсын валютын сан
ОУДД	Олон Улсын давхар даатгал
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СЯ	Сангийн яам
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ҮДД ХК	Үндэсний давхар даатгал ХК
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХК	Хувьцаат компани
ХО	Хөрөнгө оруулалт
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. ДНБ, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа /их наяд төгрөг/.....	8
График 2. Инфляцын түвшин /Улсын хэмжээнд/	9
График 3. Гадаад худалдааны тэнцэл /ам доллар/.....	9
График 4. Үнэт цаасны зах зээлийн арилжаа /тэрбум төгрөг/.....	11
График 5. Дэлхийн томоохон давхар даатгагчдын харьцаа.....	12
График 6. Олон улсын давхар даатгалын нийт хөрөнгө /тэрбум доллар/	13
График 7. График 16. Давхар даатгалын нийт хураамж /сая доллар/.....	13
График 8. Даатгалын нийт хураамж /сая доллар/.....	13
График 9. Даатгалын компаниудын нийт хөрөнгө /тэрбум төгрөг/.....	14
График 10. Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь	15
График 11. Давхар даатгалын нөхөн төлбөр /тэрбум төгрөг/.....	15
График 12. Даатгалын салбарын нөөц сан /тэрбум төгрөг/.....	16
График 13. Даатгалын компаниудын цэвэр ашгийн үзүүлэлт /тэрбум төгрөг/.....	17
График 14. Голлох харьцаа үзүүлэлтүүд.....	17
График 15. Давхар даатгалын хураамжийн зардлын прогноз /тэрбум төгрөг/.....	19
График 16. МИД-ын бүтээгдэхүүний хураамжийн орлого /сая төгрөгөөр/	32
График 17. МИД-ын хураамжийн орлого болон нөхөн төлбөр /2006-2022 он/.....	33
График 18. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	40
График 19. Орон сууцны ипотекийн зээлийн нийт санхүүжилт /тэрбум төгрөг/.....	54

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн төлөв	8
Хүснэгт 2. Улсын төсвийн гүйцэтгэл болон батлагдсан төсөв	10
Хүснэгт 3. Хувь оролцооны давхар даатгалын хураамжийн таамаглал	19
Хүснэгт 4. Даатгалын хураамжийн орлогын төсөөлөл /2022-2026 он/.....	31
Хүснэгт 5. МИД-ын даатгалын үнэлгээ, ҮДД ХК-ийн хариуцлагын дээд хэмжээ.....	33
Хүснэгт 6. Улаан буудайн даатгалын үнэлгээ, ҮДД ХК-ийн хариуцлагын дээд хэмжээ...	34
Хүснэгт 7. Даатгалын төсөөлөл (2022-2026 он).....	35
Хүснэгт 8. Бусад даатгалын бүтээгдэхүүний ҮДД ХК-ийн хураамж.....	36
Хүснэгт 9. Хүлээж чадах нийт эрсдэлийн дээд хязгаар болон даатгалын нэг гэрээгээр хүлээх дээд хэмжээ /2022 он/.....	37
Хүснэгт 10. Гэрээт давхар даатгалын гэрээний хураамжийн орлого /2023 он/.....	37
Хүснэгт 11. Хүлээж чадах нийт эрсдэлийн дээд хязгаар болон даатгалын нэг гэрээгээр хүлээх дээд хэмжээ /2022 он/.....	38
Хүснэгт 12. Урьдчилан тооцсон дундаж хүүгийн түвшин.....	40
Хүснэгт 13. Хөрөнгө оруулалтанд байршуулах дүн /тэрбум төгрөг/	40
Хүснэгт 14. Хөрөнгө оруулалтын өгөөж /тэрбум төгрөг/	41
Хүснэгт 15. Санхүүгийн төсөөлөл 2022-2026 он /сая төгрөг/.....	41
Хүснэгт 16. Балансын бүтэц - Хөрөнгө 2023-2026 он /сая төгрөг/.....	42
Хүснэгт 17. Балансын бүтэц - Өр төлбөр ба Эздийн өмч 2023-2026 он /сая төгрөг/.....	42
Хүснэгт 18. МИД-ын маркетингийн төлөвлөгөө	44
Хүснэгт 19. Үндэсний давхар даатгал ХК-тай хамтрагч давхар даатгалын компаниуд	51
Хүснэгт 20. Нөхцөл байдал, хийх ажлын хураангуй	51
Хүснэгт 21. Баталгаа шаардах тендерийн зах зээлийн тойм дүн /тэрбум төгрөг/.....	53

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Байгууллагын бүтэц.....	47
Зураг 2. Гамшгийн бондын үйл ажиллагааны схем	57

I. УДИРТГАЛ

Үндэсний давхар даатгал ХК нь 2022-2026 онд Монгол Улсын санхүүгийн зах зээл, дэлхийн болон улс орны эдийн засгийн орчин нөхцөл, УИХ, Засгийн газрын бодлого, чиглэлд нийцүүлж дотоод, гадаад нөөц бололцоогоо дайчлан үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, компанийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, компанийн ашгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлээд байна.

МУЗГ-ын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн Зорилт 4 - “*Даатгалын зах зээлийн дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлнэ*”, мөн Зорилт 3.1.7 – “*Гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, даатгалын эрсдэлийг нэгдсэн журмаар олон улсад гаргаж, зардлыг бууруулах зорилгоор давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно*”; УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.9-т заасан “*Давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно*” гэж тус тус заасан Монгол Улсын хөгжлийг тодорхойлох бодлогын баримт бичгүүдтэй, мөн МУЗГ-ын 2022 оны 16 дугаар “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах” тухай тогтоолтой уялдуулан 2022-2026 оны бизнес төлөвлөгөөг боловсрууллаа.

Цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаа нь Даатгалын тухай хууль, СЗХ-оос баталсан Даатгалын багц дүрэм болон дотоодын зах зээлд шаардлагатай байгаа санхүүгийн шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох замаар даатгуулагчийн үйл ажиллагааг эрсдэлээс хамгаалах, олон улсын зах зээлд үйл ажиллагаа явуулахад зөвлөгөө үзүүлэх, даатгалын үйлчилгээгээр хангах, мөн байгалийн гамшигт үзэгдлийг иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийг хохирол багатай даван туулахад чиглэсэн бодлого баримтална.

II. ГАДААД, ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ


2.1. ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Монгол улсын бодит дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2009-2019 оны хооронд 10 жил тасралтгүй өссөн бөгөөд 2019 онд 37.8 их наяд төгрөгт хүрсэн. Гэвч 2020 онд тулгарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхий дахинд түүхий эдийн эрэлт эрс буурч үнэ нь огцом унасан, улс орны хэмжээнд тогтоосон ээлжит хөл хорио, ялангуяа БНХАУ-тай хилээ хаасан нь эдийн засгийн өсөлт удаашрах шалтгаан болов. 2021 онд бодит ДНБ өсөлт 43.6 их наяд төгрөг болж 2020 онтой харьцуулахад 1.6%-ийн цэвэр өсөлтийг үзүүлсэн.

2017 онд бодит ДНБ-ийн 1.1 их наяд төгрөг буюу 4%-ийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа бүрдүүлж байна. Энэ нь сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй өсч 2021 оны жилийн эцсийн байдлаар 2.1 их наяд төгрөгийн үзүүлэлттэй байна.

График 1. ДНБ, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа /их наяд төгрөг/



Дэлхийн банкны судалгаагаар 2021 оны эхний улиралд Монгол улсын нүүрсний олборлолт эрчимтэй нэмэгдсэний нөлөөгөөр эдийн засаг хүчтэй сэргэсэн хэдий ч худалдааны салбар зогсонги байдалд орсны улмаас сүүлийн 3 улиралд өсөлт удааширсан. 2021 оны II улиралд Монгол улсад Ковид-19-ийн хязгаарлалтыг харьцангуй сулруулснаар үйлчилгээний салбар сэргэж улмаар ДНБ-ий өсөлтийн 1.8 хувийг эзэлсэн үзүүлэлттэй байна. Дэлхийн банкны судлаачдын таамаглалаар Монгол Улсын эдийн засаг 2022 онд дунджаар 2.5%-иар өсөх хүлээлттэй байна.

Хүснэгт 1. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн төлөв


Байгууллага	Шинэчилсэн огноо	2022*	2023*	2024*
World Bank	2022.04	2.5%	5.8%	6.8%
ADB	2022.09	1.7%	4.9%	
IMF		2.5%	4.0%	6.1%
BOM	2022.09	3%	4%	

Олон улсын шинжээчдийн таамаглалаар Монгол улсын эдийн засаг 2023 онд дунджаар 4.9 хувиар өсөх хүлээлттэй байна. Дэлхийн банкны зүгээс Монгол Улсын эдийн засаг 2022 онд дунджаар 2.5 хувиар өсч улмаар 2024 онд 6.8 хувийн үзүүлэлтэд хүрнэ гэх таамаглалыг дэвшүүлсэн бол Азийн хөгжлийн банкны зүгээс 2022 онд 1.7 хувь, 2023 онд 4.9 хувиар өснө гэж таамаглажээ.

Монгол банкны зүгээс 2022 оны 9 дүгээр сарын “Эдийн засгийн төлөв” тайланд дурдсанаар экспорт хэвийн түвшинд хүрч, зээлийн тасалдал нийлүүлэлтийн шинэ шок үүсэхгүй байх тохиолдолд 2023 онд эдийн засаг 4 орчим хувь өсөх таамаглал дэвшүүлсэн.

Инфляц


График 2. Инфляцын түвшин /Улсын хэмжээнд/



Дэлхий даяар эдийн засгийн сэргэлттэй холбоотой бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт болон тээврийн зардлын өсөлт зэрэгтэй холбоотойгоор инфляцын түвшин нэмэгдсэн. 2022 оны III улирлын байдлаар Монгол улсын инфляцын түвшин боомтын үйл ажиллагааны тасалдал, Орос Украины дайны асуудал, өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт зэргээс шалтгаалан 14.5%-д хүрсэн.

Гадаад сектор

График 3. Гадаад худалдааны тэнцэл /ам доллар/



2021 оны гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3,220.6 сая ам.доллар буюу 24.9 хувиар өссөн. Үүнд экспорт 1,670.79 сая ам.доллараар буюу 22.0 хувиар, импорт 1,549.69 сая ам.доллараар буюу 29.0 хувиар өссөн үзүүлэлт нөлөөлжээ.

Улсын төсөв

Улсын төсөв сүүлийн 10 жилийн хугацаанд алдагдалтай явснаар өр хуримтлагдаж улмаар уул уурхай олборлох салбарын хөрөнгийн урсгалаас Монгол улсын эдийн засаг ихээхэн хамааралтай болсон. Мөн сүүлийн жилүүдийн улсын төсвөөс харахад төсвийн зардлын дийлэнх хэсгийг урсгал зардал эзэлж байгаа үзүүлэлттэй байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 14.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.8 их наяд төгрөг буюу 36.5 хувиар, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 12.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.2 их наяд төгрөгөөр буюу 34.1 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Улсын төсвийн гүйцэтгэл болон батлагдсан төсөв

Үзүүлэлт, (тэрбум төгрөгөөр)	2022	2021	2021	2020
	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл
Нийт орлого	16,415.10	14,255.20	13,731.70	10,402.00
Ирээдүйн өв сан	643.4	937.9		914.1
Тогтворжуулалтын сан	0	627.9		66.2
Тэнцвэржүүлсэн орлого	15,771.70	12,689.40	12,056.50	9,421.60
Татварын орлого	13,941.30	11,262.80		8,501.80
Татварын бус орлого	1,830.40	1,426.60		919.9
Нийт зардал	18,158.80	15,598.10	15,748.30	13,960.80
Урсгал зардал	13,307.30	12,754.40		10,871.60
Хөрөнгийн зардал	5,116.10	3,047.00		3,051.70
Цэвэр зээл	-264.6		-351.1	37.6
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,387.10	-3,691.80	-2,908.80	-4,539.10

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд 2022 оны улсын төсвийн алдагдал ДНБ-ий 5.1%-иас хэтрэхгүй, 2022, 2023 онуудад 3.6%, 2.8%-иас тус тус хэтрэхгүй байхаар төсөөлжээ.

2.2. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадвар


2021 онд Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6.0 их наяд төгрөгт хүрч, 2020 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 97.5 хувиар өссөн. Энэхүү өсөлтөд ТОП-20 индекс 2021 оны эхэн үеэс эхлэн хурдацтай өссөөр 2021 оны 9 сард түүхэн дээд дүн болох 49,252 нэгжид хүрсэн нь нөлөөлсөн. 2022 оны III улирлын байдлаар ТОП-20 индекс 34,024.3, хөрөнгийн зах зээл 5.3 их наяд төгрөгийн үнэлгээтэй байна.

Үнэт цаасны зах зээлийн арилжаа

2022 оны III улирлын байдлаар нийт арилжааны 32 хувийг компанийн бонд, 1 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 21.2 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 45.8 хувийг хувьцааны арилжаа тус тус эзэлж байна. Нийт 328.4 тэрбум төгрөгийн үнэт цаас зах

зээлд арилжаалагдсан бөгөөд энэ нь 2021 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 76 хувиар буурсан үзүүлэлт юм.

График 4. Үнэт цаасны зах зээлийн арилжаа /тэрбум төгрөг/




2.3. ОЛОН УЛСЫН ДАВХАР ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Даатгалын салбарт үнэлгээ хийдэг, олон улсын тэргүүлэгч АМ Бест агентлагийн мэдээлснээр дэлхий нийтээр тархсан Ковид-19 цар тахлын улмаас эдийн засгийн болон бусад салбарт үүссэн хохирол, мөн олон давтамжтай тохиолдсон дунд хэмжээний гамшгийн хохирлууд томоохон давхар даатгагчдын даатгалын гэрээний үнийг өсгөхөд хүргэсэн байна. Давхар даатгалын гэрээнүүд илүү хатуу нөхцөлтэй хийгдэж эхэлсэн ба тодорхойгүй нэхэмжлэлүүд болон их хэмжээний нөхөн төлбөрийг барагдуулахад давхар даатгагчдын учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн хэмжээг бууруулж байгаа ба тус санг буцаан нэмэгдүүлэхэд тодорхой хугацаа шаардахаар болжээ.

Олон улсын давхар даатгалын салбар 2021 оны байдлаар 520.0 тэрбум ам.долларын үнэлгээтэй байгаа ба цар тахлын нөлөөгөөр их хэмжээний нөхөн төлбөр гарсан нь дэлхийн томоохон давхар даатгагчдын хохирлын харьцааг 7-20 хувиар нэмэгдүүлсэн байна. Хамгийн том хохирол Лойдсийн /Lloyd's/ арга хэмжээ цуцлалт болон бизнес тасалдлын даатгалын хэлбэрт гарчээ. Мэдэгдэж байгаагаар нийт 40.0 тэрбум ам.долларын нөхөн төлбөрийг цар тахлын улмаас үүссэн хохирлыг барагдуулахад зарцуулсан байна.

График 5. Дэлхийн томоохон давхар даатгагчдын харьцаа



Эх сурвалж: АМ Бест агентлаа


Цар тахлаас болж зарим оронд нас баралт ихэссэн нь амьдралын даатгагчдад нөлөөлж байгаа бөгөөд эрүүл мэндийн даатгалын хураамж даатгалын нийт багцад бага хувийг эзэлдэг байсан ч цар тахлын дараагаас нэмэгдэж эхэлсэн байна.

Давхар даатгагчдын хувьд анхаарах өөр хүчин зүйл нь хадгаламжийн хүү бага орчинд хөрөнгө оруулах нэмэлт суваг дутмаг байгаагаас андеррайтингийн орлогодоо анхаарах шаардлага үүсгэж байна. Уг асуудал нь Үндэсний давхар даатгал ХК-ийн хувьд мөн тулгамдсан асуудал болж байгаа бөгөөд компанийн зүгээс андеррайтингийн орлогодоо анхаарч ажиллах зайлшгүй шаардлагыг үүсгэж байна.

АМ Бест болон Фич агентлагийн үзэж байгаагаар цар тахлын дараагаас эхлэх эдийн засгийн идэвхжил хүчтэй сэргэж, цар тахлаас үүссэн хохирол буурснаар ирэх 2022 онд даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлт мэдэгдэхүйц сайжирна гэжээ. Дэлхийн томоохон даатгагчид 2020, 2021 онуудад их хэмжээний нөхөн төлбөр олгосон ч өөрийн хөрөнгийн хүрэлцээг ханган ажилласан, мөн эрсдэлийн удирдлагаа ухаалгаар төлөвлөсөн нь жин дарахуйц санхүүгийн өөрчлөлт үзүүлээгүй бөгөөд даатгалын салбарын хэтийн төлөвийг "тогтвортой" -оос "сайжирч буй" /improving/ болгож өөрчилсөн байна.

Олон улсын давхар даатгалын нийт хөрөнгө

График 6. Олон улсын давхар даатгалын нийт хөрөнгө /тэрбум доллар/



АНУ-ын Иллоной мужид төвтэй Gallagher RE олон улсын даатгалын фирмийн 2022 оны эхний хагас жилийн тайланд дурдсанаар нийт давхар даатгалын зах зээлийн үнэлгээ 2021 онд 728 тэрбум ам.долларт хүрсэн. Энэ үзүүлэлт нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар 11.1 хувиар буурсан байна. Тус тайланд дурдсанаар давхар даатгалын компаниудын хураамжийн хэмжээ 2022 оны эхний хагас жилд 14 хувиар

өссөн ба хохирлын харьцаа 2021 оны мөн үеэс 1.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн давхар даатгалын салбарын ашигт ажиллагаа сайжирсан хэмээн тус тайланд дурджээ.

Давхар даатгалын нийт хураамж

График 8. Даатгалын нийт хураамж /сая доллар/





График 7. Давхар даатгалын нийт хураамж /сая доллар/



Олон улсын даатгалын хяналтын холбоо /IAIS/-ны Олон улсын даатгалын зах зээлийн тайлан /GIMR/-д 2021 оны эцсийн байдлаар нийт даатгалын зах зээлийн хураамж 6 их наяд долларт хүрсэн ба үүний тал хувийг АНУ дангаараа бүрдүүлсэн байна.

Олон улсын давхар даатгалын зах зээлийн хэмжээ 483 тэрбум доллар бөгөөд энэ нь нийт даатгалын хураамжийн 8.1 хувийг бүрдүүлж буй үзүүлэлт юм.

2.4. ДОТООДЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2022 оны III дугаар улирлын байдлаар Монгол Улсын даатгалын салбарт ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, давхар даатгалын 1 компани үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын зах зээлд 2,755 тусгай зөвшөөрөл бүхий эрх эзэмшигчид үйл ажиллагаа эрхэлж байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгө

Монгол улсын давхар даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 2019 онд 75.4 тэрбум төгрөгт хүрч түүхэн дээд цэгтээ хүрэв. Гэвч энэхүү үзүүлэлт 2020 онд 55.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеээс 26.7 хувиар буурчээ.

2022 оны III улирлын байдлаар давхар даатгалын компани нь 60.2 тэрбум төгрөгний нийт хөрөнгийн үзүүлэлттэй байгаа энэ нь салбарын нийт хөрөнгийн 14.4 хувийг эзэлж байна.

2022 оны III улирлын байдлаар ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 379.3 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 84.4 хувийг бүрдүүлж байна. Урт хугацаат даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 2021 оны III улиралд 10.1 тэрбум төгрөгт хүрсэн ба салбарын 2.2 хувийг эзэлж байна.

График 9. Даатгалын компаниудын нийт хөрөнгө /тэрбум төгрөг/






График 10. Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын нөхөн төлбөр

График 11. Давхар даатгалын нөхөн төлбөр /тэрбум төгрөг/




Давхар даатгалын нөхөн төлбөрийн дүн 2019 онд түүхэн дээд цэг буюу 11.8 тэрбум төгрөгт хүрсэн. Гэвч тус үзүүлэлт 2021 онд 58 хувиар буурч, 4.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ.

2022 оны III улирлын байдлаар даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 68.9 тэрбум төгрөгт хүрсэн ба үүний 98.7 хувийг ердийн даатгалын компаниудын эзэлж байна.

Даатгалын салбарын нөөц сан

График 12. Даатгалын салбарын нөөц сан /тэрбум төгрөг/




Ердийн даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ жил тутам өссөн үзүүлэлттэй байна. 2022 оны III улирлын байдлаар ердийн даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 174.8 тэрбум төгрөгт хүрч 2021 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 11 тэрбум төгрөгөөр өссөн байна. 2022 оны III улирлын байдлаар даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ 209 тэрбум төгрөгт хүрч 2021 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 15.3 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна.

Даатгалын компаниудын цэвэр ашгийн үзүүлэлт

2022 оны III улирлын байдлаар даатгалын компаниудын цэвэр ашиг 14.1 тэрбум төгрөгт хүрсэн. Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан 7 компани, 50 хувь хүртэлх өсөлттэй 4 компани, 50-100 хувийн өсөлттэй 1 компани, 100 хувиас дээш өсөлттэй 5 даатгалын компани байна.


График 13. Даатгалын компаниудын цэвэр ашгийн үзүүлэлт /тэрбум төгрөг/



Голлох харьцаа үзүүлэлтүүд

2021 онд даатгалын зах зээлийн голлох харьцаа үзүүлэлтүүд болох зардлын харьцаа 62.9 хувь, хохирол нөхөлтийн харьцаа 49.6 хувь, хосолсон харьцаа 112.5 хувь, цэвэр ахиуц ашиг 10.2 хувьтай байна. 2022 оны III улирлын байдлаар хохирол нөхөлтийн харьцаа 53.1 хувь, зардлын харьцаа 59.9 хувь, цэвэр ахиуц ашгийн харьцаа 6.4 хувь байна. 2020-2021 онд хохирол нөхөлтийн харьцаа болон хосолсон харьцаа, зардлын харьцаа өссөн үзүүлэлттэй байна.

График 14. Голлох харьцаа үзүүлэлтүүд



Даатгалын салбарын нягтрал, гүнзгийрэлт

Монгол Улсын даатгалын салбарт тодорхой ахиц дэвшлүүд гарч, даатгалын зах зээлийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд буураагүй ч ерөнхийд нь дүгнэвэл өсөлт, хөгжил нь удаашралтай байна. Тухайлбал, олон улсад даатгалын салбарын хөгжлийг тухайн орны даатгалын гүнзгийрэлт болон даатгалын нягтрал ямар түвшинд байгаагаар хэмжиж, харьцуулдаг бөгөөд тэдгээр үзүүлэлтүүд нь Монгол Улсын хувьд дараах байдалтай байна. Үүнд:

- Даатгалын нягтрал буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь 2010-2021 оны хооронд тасралтгүй өссөн. 2021 онд даатгалын нягтрал 73,462 төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэхүү үзүүлэлт нь хөгжиж буй орнуудын дундаж болох 175 ам.доллартай харьцуулахад 8.1 дахин бага байна.
- Даатгалын гүнзгийрэлт буюу дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх даатгалын хураамжийн орлогын хувь 2022 оны жилийн эцсийн байдлаар 0.63 хувьд хүрсэн нь өмнөх жилийн мөн үеэс 0.06 нэгжээр өссөн байна. Уг хэмжээ нь Свисс Ре олон улсын давхар даатгагчаас гаргасан 2019 оны судалгаанд хөгжиж буй орнуудын даатгалын гүнзгийрэлтийн дундаж үзүүлэлт болох 3.3 хувьтай харьцуулахад 6.1 дахин бага байгаа нь Монголын даатгалын зах зээл хэр зэрэг нөөц бололцоотой буюу цаашид өсөх боломжтой болохыг харуулж байна.

2.5. ДОТООДЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Хууль эрх зүйн орчин – Даатгалын тухай хууль

Сангийн яам болон СЗХ хамтран Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Үндэсний давхар даатгал ХК-аас төлөөлөл орон ажиллаж байгаа билээ.

Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөлд:


- Дотоодын давхар даатгагчдыг дэмжих;
- Урт хугацааны буюу амьдралын даатгалын үйл ажиллагааг сайжруулж, хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгон нийгмийн дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, эрсдэлийг шилжүүлэх дотоодын хэрэглээг нэмэгдүүлэх;
- Дотоодын давхар даатгагчдыг дэмжих эрх зүйн зохицуулалт, даатгалын компаниудын гадаад хамтын ажиллагаа, гадаад зах зээлээс хөрөнгө татах боломжийг нэмэгдүүлэх замаар дотоодын хөрөнгийн зах зээлийн томоохон хөрөнгө оруулагчдыг бий болгох, даатгалын зах зээл болон хөрөнгийн зах зээлийн уялдаа холбоог бэхжүүлэх;
- Хариуцлагын даатгалын үйл ажиллагааг сайжруулах замаар иргэн, ААН, төрд үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулж, олон давхаргат даатгалын тогтолцоог бүрдүүлэн хариуцлагатай нийгэм, эдийн засгийг бий болгох;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр томоохон эрсдэлийг даатгах тендерт дотоодын даатгалын компаниуд хамтарч оролцох зохицуулалтыг бий болгож хам

даатгалын үйл ажиллагааг хөгжүүлж, улмаар даатгалын хураамжийн зохистой хувийг дотоодод үлдээн, валютын гадагшлах урсгалын бууруулах зэрэг зохицуулалтууд тусгагдахаар байна.

Мөн тус хуулийн төслийн 52 дугаар зүйлд даатгагч нь даатгалын гэрээний хүлээсэн үүргийн тодорхой хувийг Үндэсний давхар даатгал ХК-д давхар даатгуулна гэсэн заалт орсон нь Үндэсний давхар даатгал ХК-ийн хураамжийн орлого болон нөөц сангийн хэмжээнд шууд нөлөөлөхөөр байна.

Уг заалттай холбогдуулан давхар даатгалын хураамжийн таамаглалыг СЗХ болон МДХ улирал бүр эмхлэн гаргадаг даатгалын салбарын санхүүгийн тайлан мэдээг үндэслэн таамаглавал даатгалын зах зээлийн мэдээллээр 2021 онд 15 хэлбэрээр нийт 84.3 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг олон улсын давхар даатгалд шилжүүлсэн байна. 2012 оноос хойших боломжит давхар даатгалын хураамжийн хэмжээг ашиглан 15 хэлбэрийн давхар даатгалын хураамжийн зардлын дүнг 2024 он хүртэл экспоненциал тэгшитгэх /exponential smoothing/ хугацаан цувааны арга ашиглан таамагласныг График 8-д доод, дээд хязгаарын хамт үзүүлээ. Доод, дээд хязгаар нь 95 хувийн итгэх түвшинд тооцоологдсон бөгөөд 95 хувийн итгэх түвшинд 2022 онд давхар даатгалд шилжүүлэх хураамж нь 74.6 тэрбум төгрөгөөс 95.5 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэнэ.

График 15. Давхар даатгалын хураамжийн зардлын прогноз /тэрбум төгрөг/



Хувь оролцооны давхар даатгалын гэрээг 10 – 25 хувийн оролцоотой байгуулахад 2026 он хүртэлх дотооддоо авч үлдэх давхар даатгалын хураамж Хүснэгт 4-т үзүүлсэн хэмжээнд байхаар байна.

Хүснэгт 3. Хувь оролцооны давхар даатгалын хураамжийн таамаглал

		10%	15%	20%	25%
1.	2022	8,437,470,000	12,656,205,000	16,874,940,000	21,093,675,000
2.	2023	8,509,735,679	12,764,603,519	17,019,471,358	21,274,339,198
3.	2024	9,371,464,280	14,057,196,421	18,742,928,561	23,428,660,701
4.	2025	9,729,210,887	14,593,816,330	19,458,421,774	24,323,027,217

5. 2026	10,590,939,488	15,886,409,232	21,181,878,976	26,477,348,721
---------	----------------	----------------	----------------	----------------

Даатгалын гэрээний 15 хувь буюу түүнээс бага хувийг дотооддоо авч үлдэх нь даатгалын үйл ажиллагаанаас гарах үр дүн багатай буюу гадагш гарах мөнгөн урсгалыг бууруулах зорилгодоо бүрэн хүрч чадахгүй байна. Эрсдэл даах чадвар, даатгалын хэлбэр бүрээр гаргасан учирч болох хохирлын харьцаа, нөөц сангийн чадамж болон алдагдлаас хамгаалах санд ирэх ачааллыг харгалзан үзээд давхар даатгалын зах зээлийн 20 хувиас ихгүй хэмжээний хариуцлагыг Үндэсний давхар даатгал ХК шилжүүлэн авах боломжтой байна.

Дээрх хураамжийн таамаглал нь Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт батлагдсан тохиолдолд хэрэгжих юм.

Хууль эрх зүйн орчин – Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл 2022 оны 12 дугаар сарын 17-нд батлагдсан бөгөөд тендерт оролцогч аж ахуйн нэгжүүд аливаа баталгааг гаргуулахдаа даатгагчийн баталгааг ашиглах, иргэд ипотекийн зээл авахад урьдчилгаа төлбөрийн тодорхой хувьд мөн даатгагчийг баталгааг ашиглах боломжтой болсон нь Үндэсний давхар даатгал ХК-ийн 2022-2026 оны бизнес төлөвлөгөөний зорилт болох шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний зорилттой нийцэж байна.

Төсөл хөтөлбөрүүд

Монгол Улсын гамшгийн эрсдэлийг үнэлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг боловсруулах, сургалтыг зохион байгуулах, гамшгийн эрсдэлийн даатгалын хуулийн төслийг боловсруулах, эрх зүйн орчныг бэхжүүлэх “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх” техник туслалцааны төсөл ОБЕГ-т хэрэгжиж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хууль боловсруулах ба тус хууль батлагдсан тохиолдолд Үндэсний давхар даатгал ХК-ийн оролцоо чухал байх юм.

III. ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Үндэсний давхар даатгал ХК нь 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хүрээнд анх Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нэртэй байгуулагдсан ба 2018 онд нэрээ өөрчилж, үйл ажиллагаагаа өргөтгөн мал амьтан, газар тариалан, хөрөнгө, хариуцлага, барилга угсралт, гэнэтийн осол, ачаа тээвэр, эрүүл мэнд, агаарын хөлөг, агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, авто тээвэр, санхүүгийн даатгалын хэлбэрүүдээр давхар даатгалын үйлчилгээ үзүүлж 2019 онд 2 тэрбум 74 сая, 2020 онд 3 тэрбум 572 сая, 2021 онд 4 тэрбум 153 сая, 2022 онд 4 тэрбум 8 сая төгрөгийн хураамж төвлөрүүлж 2019 оноос 100 хувийн өсөлт үзүүлэн ажиллаж байна. Энэ нь СЗХ-оос гаргадаг

даатгалын салбарын нэгдсэн тайланд тусгагдсан Монгол Улсаас олон улсын давхар даатгагч руу шилжүүлж буй давхар даатгалын хураамжийн 4 хувийг эзэлж байгаа юм.

Эрхэм зорилго

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгалын салбарын өсөлт, хөгжлийг дэмжинэ.

Алсын хараа

Бид Монгол Улсын даатгалын зах зээлийг олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангаж, даатгалын салбарын эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дэмжинэ.

Үнэт зүйлс

- Мэргэшсэн өндөр чадавх – Даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөц.
- Манлайлал – Цаашдын зорилго, зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлэн нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.
- Хамтын зүтгэл – Бусадтай хүндэтгэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллах, бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- Үнэнч шударга зарчим – Монгол Улсын хууль журмыг чанд мөрдөж, компанийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.
- Ил тод харилцаа холбоо – Мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, шударга, нээлттэй харилцаа холбоо тогтооно.

3.2. СВОТ ШИНЖИЛГЭЭ

Үндэсний давхар даатгал ХК-ийн үйл ажиллагааны өнөөгийн давуу болон сул талуудыг тодорхойлж, компанийн үйл ажиллагаанд тохиох магадлал өндөр дотоод, гадаад орчны боломж, аюул заналыг харгалзан үзэж бизнес төлөвлөгөөний SWOT шинжилгээг хийв.

ДОТООД ОРЧИН

ДАВУУ ТАЛ

- Дотоодын цорын ганц давхар даатгалын компани.
- Компани байгуулагдсан цагаасаа хойш үйл ажиллагааны цар хүрээг тогтмол тэлж ажилласан.
- Компанийн бодлого, үндсэн чиглэл нь улс орны эдийн засаг, төрийн бодлоготой уялдаж, стратегийн гол салбаруудыг эрсдэлээс хамгаалахад зорьж ажилладаг.
- Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дагуу орон даяар МИД-ыг зохион байгуулдаг, орон нутагт танигдсан.

СУЛ ТАЛ

- Давхар даатгалын эрх зүйн орчин сул.
- Андеррайтингийн орлого компанийн зардлыг нөхөх хэмжээнд хүрээгүй.
- Олон улсын давхар даатгагч, брокеруудтай өрсөлдөх санхүүгийн болон үйл ажиллагааны туршлага дутмаг.
- Компани олон улсын зэрэглэлгүй.
- Компанийн үйл ажиллагаанд ISO нэврүүлээгүй.
- Дотоодын даатгалын зах зээлийн багтаамж бага, даатгуулагчдын

- Олон улсын нэр хүнд бүхий давхар даатгагчидтай олон жил тууштай хамтран ажилласан.

мэдлэг хомс бөгөөд даатгалын гүнзгийрэлт бусад хөгжиж буй орнуудаас 6 дахин бага.

ГАДААД ОРЧИН

БОЛОМЖ

- Засгийн газрын дэмжлэгтэй эдийн засгийн тэргүүлэгч төсөл, хөтөлбөрүүдэд оролцох боломжтой.
- Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Гамшгийн даатгалын тухай хууль, Тариалангийн даатгалын тухай хууль болон бусад хуулийн төслүүдэд санал өгөх ажилд тэргүүлэх байр суурьтай оролцож, зохицуулалтыг бий болгох.
- Дотоодын давхар даатгалын оролцоог нэмэгдүүлэх замаар даатгалын салбарын санхүүгийн зах зээлд эзлэх хувийг өсгөх.
- Бүтээгдэхүүн үйл ажиллагааны цар хүрээг тэлэх, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх.
- Борлуулалтын сувгийг нэмэгдүүлж даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх.
- Шинээр хөрөнгө оруулалт татаж компанийн хөрөнгийг нэмэгдүүлэх.
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх.
- Олон улсын давхар даатгагчидтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага судлах.

ЭРСДЭЛ

- Цар тахал, гадаад орчин нөхцөл, олон улсын үүдэлтэй эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан төлөвлөсөн орлого буурах.
- Валютын ханш, хүүгийн түвшний хэлбэлзлээс шалтгаалан хөрөнгө оруулалтын өгөөж багасах.
- Байгалийн гамшигт үзэгдэл тохиолдоход их хэмжээний нөхөн төлбөр олгох.
- Компанийн засаглалд улс төрийн нөлөө байдаг.

Давуу талаа ашиглан эрсдэлийг бууруулах

Компани өөрийн давуу талаа ашиглан доорх эрсдэлүүдийг бууруулах боломжтой:

- Даатгалын нөөц сангуудыг нэмэгдүүлж, компанийн илүү гарсан эрсдэлийг зөв тооцоолон шилжүүлснээр том хэмжээний гамшигт үзэгдэл тохиолдоход эрсдэл даах чадвар өндөр байж, нөөц сангийн хэмжээг зохист түвшинд байлгах;
- Холбогдох журам болон эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгон, эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэн олон улсын зэрэглэл тогтоолгож, компанийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх;
- Хууль эрх зүйн орчныг сайжруулан давхар даатгалын тогтолцоог баталгаажуулах замаар компанийн андеррайтингийн ашиг, дотоодын нөөцийг нэмэгдүүлэх;

Боломжоо ашиглан сул талаа арилгах

Үндэсний давхар даатгал ХК-ийн дээр дурдсан боломжуудыг ашиглан сул талаа арилгаж давуу тал болгох боломжтой. Үүнд:

- Олон улсын давхар даатгагч болон брокер компаниудтай туршлага солилцож, компанийн ажилтнуудыг мэргэшүүлснээр чадварлаг хүний нөөцтэй болж, олон улсын давхар даатгагчидтай өрсөлдөхүйц үйлчилгээ үзүүлэн, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх;
- Давхар даатгалын хураамжийг нэмэгдүүлснээр андеррайтингийн орлогоор компанийн зардал хаах хэмжээнд хүргэх;

IV. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

4.1. НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ

УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт баталсан бөгөөд түүнд Үндэсний давхар даатгал ХК-ийн 34 хүртэлх хувийг 2023 оны нэгдүгээр улиралд багтаан олон нийтэд нээлттэй арилжаалах болсон.

Мөн Үндэсний давхар даатгал ХК-ийн алсын хараа болон Монгол Улсын хөгжлийг тодорхойлох бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудын хэрэгжилтийг хангах, мөн компанийн 2019-2021 оны бизнес төлөвлөгөөний 4 дүгээр бүлэг “Үйл ажиллагааны стратеги” хэсгийн урт хугацааны зорилт болох “Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах” зорилгод нийцэх үүднээс компани андеррайтингийн бодлого, эрсдэлийн удирдлага, комплаенсийн хэрэгжилтийг олон улсын жишигт нийцүүлэх шаардлага үүсэж байна. Компани нээлттэй хувьцаат компани болж олон улсын болон дотоодын стратегийн түншлэлийн хөрөнгө оруулагч татсанаар компанийн үйл ажиллагаанд нөү хау шилжин ирж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж нэмэгдэнэ.

4.1.1. Зорилт 1 - Компанийн санхүүгийн чадавхын олон улсын үнэлгээ тогтоолгох

Компанийн хөрөнгө, үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, олон улсын санхүүгийн болон зээлжих зэрэглэлийн үнэлгээг авах ажлын удиртгал болгон компани 2022 онд өдөр тутмын үйл ажиллагаандаа ISO стандартыг нэвтрүүлэн ажиллана. Мөн АМ Бест агентлагаас гаргасан үнэлгээ тогтоох журмын дагуу өөрийн үнэлгээг хийх бөгөөд тус үнэлгээнээс хангалтгүй хэрэгжиж буй хэсгүүдийг 2023 оноос эхлэн сайжруулж, шаардлагатай тохиолдолд дүрэм, журам болон үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталж 2024 он гэхэд олон улсын үнэлгээ тогтоолгосон байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 1-т/

Хүрэх үр дүн

Компанийн авах үнэлгээний зорилт Монгол Улсын зээлжих зэрэглэл, тухайн үеийн санхүү, эдийн засгийн байдлаас хамаарч “В+, тогтвортой” эсвэл “В, тогтвортой” байна.

4.1.2. Зорилт 2 - Компанийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх

СЗХ-ны ажлын албаны даргын 2018 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ын дагуу компанийн бүтэц, зохион байгуулалт, бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн онцлог, дата

мэдээллийн боломжийг харгалзан хамгийн тохиромжтой, хангалттай аргачлал, техникийг багтаасан “Эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлал”-ыг илүү боловсронгуй болгон, тус аргачлалын дагуу жилд 2 удаа эрсдэлээ үнэлэн тайлагнах болно.

Энэхүү аргачлал болон бусад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалыг мөрдлөг болгон компанийн учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлж, бууруулах арга замыг тодорхойлох, эрсдэлийг оновчтой удирдахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2020 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал ХК-ийн эрсдэлийн удирдлагын журам”-ын дагуу эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь компанийн удирдлага, бүх газар, нэгжийг хамарна. Гурван шатлал бүхий эрсдэлийн удирдлагын үр дүнд Гүйцэтгэх захирал шаардлагатай үед эрсдэл бууруулах, удирдах тушаалыг гаргаж, газар, нэгжүүд тус тушаалд үндэслэн холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэн, эрсдэл хариуцсан газар нь ажлын хэрэгжилтэд хяналт тавин ажилласнаар эргэх холбоо үүсгэж байгууллагын эрсдэлийн удирдлагыг шат бүрд төлөвшүүлэн ажиллана. Мөн эрсдэлийн удирдлагын процессыг сайжруулах, хялбарчлах, түүний үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх үүднээс эрсдэлийн менежментийн үе шатуудыг тодорхойлсон загварчлал, схемийг /Risk map/ байгуулж, эрсдэлийг тархаан ажиллана.

Үндэсний давхар даатгал ХК-д даатгалын гэрээний хариуцлагын дагуу хүлээж болзошгүй нөхөн төлбөр, хохирлоос үүдэх даатгалын эрсдэлийг удирдахад олон улсын давхар даатгагчид эрсдэлээ шилжүүлэх, олон жилийн хугацаанд нөөц сангаа тогтвортой нэмэгдүүлэх, нөөц сангийн тооцооллыг консерватив аргачлалаар тооцоолох зэрэг эрсдэлийн удирдлагыг ашиглана.

Хүрэх үр дүн

Эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлалыг илүү боловсронгуй болгож газар, нэгжүүдийг оролцуулан судалгааны үр дүнг тайлагнаж, хэрэгжилтэд хяналт тавих байдлаар байгууллагын эрсдэлийн удирдлагын соёлыг бий болгоно.

4.1.3. Зорилт 3 – Комплаенсийн хэрэгжилтийг хангах

Комплаенсийн эрсдэлийг бууруулахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, компанийн үйл ажиллагаанд мөрдөгддөг дүрэм, журмыг холбогдох хууль, тогтоомж болон бусад хэм хэмжээний актад нийцүүлэх зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Салбарын хэмжээнд батлагдахаар төлөвлөгдөж буй хуулийн төслүүдийн ажлын хэсэгт орж ажиллах, компанийн хэтийн төлөвт үр нөлөөтэй, үндэслэлтэй саналыг боловсруулж тусгуулах;
- Компанийн дотоод дүрэм, журмын биелэлтийг хангах, үр нөлөөг судлах;
- Компанийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актын төсөл боловсруулах, хянах, шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

Хүрэх үр дүн

Компанийн үйл ажиллагаа хууль, холбогдох журам, зааварт нийцэж, комплаенсийн эрсдэл тодорхой хэмжээнд буурна.

4.1.4. Зорилт 4 – Сайн засаглалын бүтэц, чиг үүргийг хэрэгжүүлэх

Компанийн сайн засаглалын бүтэц, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

- Байгууллагын дотоод үйл ажиллагаа, мэдээллийн урсгал, тайлагналыг сайжруулах зорилгоор олон улсад танигдсан шилдэг систем, арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх;
- Хүний нөөцийн материал бүрдүүлэлтийн нэгдсэн санг боловсронгуй болгох, холбогдох мэдээллүүдийг цахим хэлбэрт шилжүүлэх;
- Компанийн үйл ажиллагаанд үр дүнтэй аудит шалгалтыг хийж гүйцэтгэх, засаглал, хяналтын үйл явцын үр ашиг, үр нөлөөг сайжруулахад хувь нэмэр оруулах замаар байгууллагын үнэ цэнийг өсгөх, байгууллагын соёлыг бий болгож зохистой засаглалын сайн тогтолцоотой болох;
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцсэн санхүү бүртгэлийн үйл ажиллагааг нээлттэй, шинэ түвшинд хүргэх;

Хүрэх үр дүн

Компанийн хүний нөөцийн сан үүсэж, цахим хэлбэрт шилжсэн байх бөгөөд даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцтэй болно. Мөн нягтлан бодох бүртгэлийг олон улсын түвшинд хүргэж ажилласан байна.

4.1.5. Зорилт 5 – Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх

Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт, хөгжлийн бодлого хэрэгжүүлж, суралцагч байгууллага болно. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, ажлын чиг үүрэг, компанийн зорилгод үндэслэн даатгалын салбарын нэр хүндтэй институт болох Австрали, Шинэ Зеландын даатгал, санхүүгийн институт /ANZIIF/, олон улсын сертификат олгох даатгалын институт /CII/ болон бусад сургалтын байгууллагын богино, дунд, урт хугацааны академик сургалтад хамрагдан чадварлаг хүний нөөцийг бэлтгэнэ.

Хүрэх үр дүн

Хувь хүний мэдлэг, чадвар, туршлагыг байгууллагын мэдлэг, чадвар туршлага болгон хөгжүүлснээр суралцагч байгууллага болон хөгжинө. Хүний нөөцийг тогтмол хөгжүүлснээр байгууллагад өрсөлдөхүйц давуу тал бий болж, тэр хэмжээгээр баялаг бүтээх боломж нэмэгдэнэ.

4.1.6. Зорилт 6 - Нийгмийн хариуцлагатай компани байх

Монгол Улсын цор ганц давхар даатгагчийн хувьд салбартаа тэргүүлэгч, нийгмийн хариуцлагатай компани болж нийгэмдээ үр өгөөжтэй, хүрээлэн буй орчиндоо эергээр нөлөөлөх дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

- Байгаль орчинд тустай компанийн бодлого:
 - Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Үндэсний давхар даатгал ХК

нэгдэнэ.

- Боловсрол, шинжлэх ухааныг дэмжигч компанийн бодлого:
 - Боловсрол, шинжлэх ухааныг дэмжих, нийгмийг соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмэр оруулах зорилгоор санхүүгийн салбарын эрдэм шинжилгээний хурал болон иноваци технологийн шинэ бүтээлд олгодог Үндэсний давхар даатгал ХК-ийн нэрэмжит шагналыг бий болгоно.
 - Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллыг сайжруулах, тав тухтай орчинд сурч, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх зорилготой компанийн нэрэмжит төслийг бий болгон жил бүр хэрэгжүүлнэ.
- Салбарын хөгжлийг дэмжигч компанийн бодлого:
 - Байгууллагын манлайлал, компанийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, бизнесийн харилцааг өргөжүүлэх зорилгоор Даатгалын зах зээлийн оролцогчдын дунд Үндэсний давхар даатгалын нэрэмжит шилжин явах цом бүхий спортын уламжлалт арга хэмжээтэй болно.
- Ёс зүй, нийгмийн хариуцлагатай компанийн бодлого:
 - Бүх ажилтан, хамтрагч болон харилцагчидтай ёс зүйтэй, хүндэтгэлтэй харьцах зэрэг бизнесийн шударга ёсыг бүхэлд нь хэрэгжүүлэгч компани байна.
 - Эрдэнэт хүний амь насыг аврах найдвар болсон цусаа хандивлах үйлст хувь нэмрээ оруулж, сайн дурын цусны донорын эгнээг өргөжүүлэх, хүмүүнлэгийн үйлсийг олон нийтэд сурталчлан уриалах зорилгоор "Цус сэлбэлт судлалын үндэсний төв"-д цусаа бэлэглэх арга хэмжээг жил бүр компанийн бүх ажилтнуудын дунд зохион байгуулна.

4.2. ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРЛИЙГ ОЛШРУУЛЖ, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Зах зээлийн эрэлтэд нийцүүлэн компани шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, мөн орлогын эх үүсвэрийг олшруулснаар компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлнэ.

4.2.1. Зорилт 1 - Даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ

Үндэсний давхар даатгал ХК нь дотоодын даатгагчдын эрэлт хэрэгцээнд үндэслэн олон улсын зах зээлд давхар даатгадаггүй, өндөр үнэтэй, дотоодын зах зээлд хэрэгцээтэй байгаа давхар даатгалын үйлчилгээг түлхүү хэрэгжүүлнэ. Үүнд:

- Далд уул уурхайн салбарын даатгалын эрэлт хэрэгцээг хангасан бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх,
- Газрын тос, нефтийн бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлийг даатгах;
- Даатгагчийн баталгааг нэвтрүүлж зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах
- Гамшгийн даатгал,
- Бэлчээрийн даатгал зэрэг орно.

/Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т/

Хүрэх үр дүн

Компани шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, 2024 оноос эхлэн даатгалын хураамжийн орлогоор даатгалын нөөц сангуудыг бүрдүүлж, ашигтай ажиллах боломжтой байна.

4.2.2. Зорилт 2 – Олон улсын байгууллагын зээлийн андеррайтинг хийх

Монгол Улсын үйлдвэрлэл эрхлэгчид, уул уурхайн бус ААН-ыг дэмжих, тэдгээрийн хилийн чанад дах борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор экспортлогч ААН-үүдийн харилцагч олон улсын байгууллагуудын санхүүгийн чадавхын андеррайтингийн үйлчилгээг үзүүлнэ. Экспортын даатгалыг нэвтрүүлэх, хөгжүүлэх хүрээнд хамтран ажиллаж буй Тинүбү Скүэр групптэй хамтран уг үйлчилгээг нэвтрүүлэх бөгөөд экспортлох боломжтой ААН-үүдэд гадаад харилцагчаа танин мэдэх, хилийн чанад дах эрсдэлээ бууруулах нэг санхүүгийн хэрэгсэл болох юм.

Хүрэх үр дүн

Экспортлогчдод харилцагч байгууллагуудын санхүүгийн чадавхын мэдээллийг үнэн зөв өгч, хамтран ажилласан байна.

4.2.3. Зорилт 3 – Олон улсын зах зээлд давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх

Компани хамтран ажилладаг брокерууд болон давхар даатгагчтай хамтран олон улсын давхар даатгалын гэрээний тодорхой хувьд даатгалын үйлчилгээ үзүүлнэ. Компани олон улсын үнэлгээ тогтоолгосноор даатгалын санал авах нь ихсэх бөгөөд даатгалын багцаа дан бүтээгдэхүүний хэлбэрийн хувьд бус газар зүйн байршлын хувьд төрөлжүүлэх боломжтой болно.

Хүрэх үр дүн

Олон улсын зах зээлд давхар даатгалын үйлчилгээ үзүүлсэн байна.

4.2.4. Зорилт 4 – Гамшгийн бонд гаргах, удирдах

Кат бонд буюу гамшгийн бонд нь 2010 оноос хойш хэрэгцээ нь нэмэгдсэн ба дэлхийн улс орнууд гамшигт өртсөний дараа хурдан хугацаанд хохирлыг нөхөх, хөрөнгийг босгох боломжийг олгодог. Гамшгийн бонд нь даатгалын компани, тэр ч байтугай улс орныг эдийн засгийн алдагдлаас хамгаалахын тулд ашигладаг хамгийн боловсронгуй хэрэгслүүдийн нэг юм. Макро эдийн засгийн хүчин зүйлүүд мөн хөрөнгийн зах зээлийн эрсдэл, хүүгийн эрсдэл, зээлийн эрсдэл, инфляц зэрэг бусад эрсдэлтэй бараг хамааралгүй байгаа нь тогтвортой, хурдацтай өсөх магадлалтайг харуулдаг. Гамшгийн бонд нь хөрөнгө оруулагчдын үндсэн төлбөрийг хамгийн эрсдэл багатай найдвартай үнэт цаасанд оруулдаг санхүүгийн бүтээгдэхүүн юм.

Байгалийн гамшигт үзэгдлээс бий болох хохирлыг барагдуулахын тулд бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийг эрсдэл багатай, хөрвөх чадвар сайтай хөрөнгө оруулалтын

хэлбэрүүдэд байршуулж үүнээс бий болох ашгаар бондын хүүгийн төлөлтийг хийх боломжтой. /Дэлгэрэнгүйг Хавсралт 3-т/

Хүрэх үр дүн

Гамшгийн бондыг удирдах, зарцуулах журмыг боловсруулан, гамшгийн бондын бүтээгдэхүүн гаргаж сонирхогч талуудад танилцуулсан байна.

4.3. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Үндэсний давхар даатгал ХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, цар хүрээгээ нэмэгдүүлэх томоохон хөшүүрэг нь давхар даатгалын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцож буй олон улсын болон дотоодын харилцагч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх явдал юм.

4.3.1. Зорилт 1 – Гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

Мэргэжлийн холбоод

Үндэсний давхар даатгал ХК нь Азийн давхар даатгалын холбооны үндсэн гишүүн ба дэлхийн экспортын зээлийн агентлаг, экспортын зээлийн даатгалын байгууллагуудын хамгийн том холбоо болох Берн Юнионд 2017-2019 онд ажиглагч гишүүн байсан бөгөөд 2023 онд үндсэн гишүүн мөн Азийн батлан даалт, зээлийн даатгалын холбоонд гишүүн болохоор зорин ажиллаж байна. Тус холбоодын жил бүрийн нэгдсэн уулзалтад оролцож бусад нэр хүнд бүхий байгууллагын төлөөллүүдтэй холбогдон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллана.

Давхар даатгагч болон зуучлагч компаниуд

Компани нь олон улсын "А" зэрэглэлийн СКОР, Свисс Ре, Ханновер ре, Жи Ай Си Ре, Тайпинг Ре, Пик Ре зэрэг давхар даатгагчидтай даатгалын гэрээ байгуулан өөрийн эрсдэлийн тодорхой хувийг шилжүүлэн ажилладаг бөгөөд цаашид олон улсын топ зэрэглэлийн давхар даатгагч болон давхар даатгалын зуучлагч компаниудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, компанийн хариуцлагаас давсан эрсдэлийг шилжүүлэн ажиллана. Мөн стратегийн түншлэгч болох боломжтой давхар даатгагчидтай компанийн ажилтнуудаас мэргэжлийн дадлага хийлгэж, туршлага судлах зорилго тавин ажиллана.

Хүрэх үр дүн

Олон улсын топ даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай холбоо тогтоон хамтран ажиллаж, туршлага судлан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний судалгаа хийж, зах зээлд нэвтрүүлсэн байна.

4.3.2. Зорилт 2 - Дотоод хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

Даатгалын компани болон давхар даатгалын зуучлагч компаниуд

Даатгалын компани, даатгалын болон давхар даатгалын зуучлагч компаниудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлснээр салбарын эрэлт хэрэгцээг илрүүлэх, тэдгээрийн хүсэл сонирхолд нийцсэн давхар даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, эрсдэлийн

хуваарилалтыг илүү үр дүнтэй, харилцан ашигтайгаар хийх боломжийг бий болгохоос гадна давхар даатгалын хураамжийн орлогыг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй.

Зохицуулалтын байгууллагууд

Давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэхэд хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх нэн шаардлагатай байна. Тиймээс компанийн зүгээс ойрын хугацаанд шинэчлэн батлахаар хуулийн төслийг боловсруулаад байгаа Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн ажлын хэсгийн оролцоогоо нэмэгдүүлж, давхар даатгалын бодлогыг дэмжсэн оновчтой зохицуулалтыг тусгах чиглэлээр Сангийн яам, СЗХ-той хамтран ажиллана.

Банк, санхүүгийн байгууллагууд

Банк санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлснээр тэдгээрийн зах зээлд нийлүүлж буй санхүүгийн бүтээгдэхүүнүүдтэй уялдуулан давхар даатгал, хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой. Одоогийн байдлаар хөрөнгө оруулалтаас гадна мал амьтдын даатгал, зээлийн даатгал, хөрөнгийн даатгалын хэлбэрүүд дээр хамтран ажиллаж байгаа бөгөөд компанийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдэхийн хэрээр хамтын ажиллагаа хүрээгээ тэлэх хандлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компаниуд

Үндэсний давхар даатгал ХК нь төрийн өмчит компани хоорондын хамтын ажиллагааг бий болгон зарим томоохон төрийн өмчит компаниудад давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, хамтран ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, тус компаниудын эрсдэлийг даатгалын компаниуд болон олон улсын давхар даатгагч нартай хамтран хариуцсанаар давхар даатгалын хураамжийн орлогыг нэмэгдүүлж, валютын гадагшлах урсгалын бууруулах ач холбогдолтой юм.

Хүрэх үр дүн

Дотоодын байгууллагуудтай харилцан ашигтай хамтран ажиллаж, компанийн үйл ажиллагааг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх бодит үр дүнд хүрсэн байна.

4.4. ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ӨГӨГДЛИЙН САНТАЙ БОЛОХ

ОБЕГ, Одон орон геофизикийн хүрээлэн, Ус цаг уурын хүрээлэнтэй хамтран Монгол Улсад тохиолдож буй байгалийн гамшигт үзэгдлийн давтамж, тоон үзүүлэлтүүд зэргийг харуулах түүхэн мэдээллийг багтаасан өгөгдлийн нэгдсэн сантай болох зорилго тавин ажиллаж байна. Ингэснээр гамшгийн даатгалыг хэрэгжүүлэх нэгэн үндсэн суурь болно.

Хүрэх үр дүн

Гамшгийн эрсдэлийн өгөгдлийн сантай болсон байна.

4.5. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ

Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон компанийн үйл ажиллагаатай холбогдох бусад хуулийн төслийн ажлын хэсэгт орж ажиллах, хуулийн төсөлд компанийн үйл ажиллагаа, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр ач холбогдолтой зохицуулалт тусгуулах талаар ажлын хэсэгтэй нягт хамтран ажиллана.

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Даатгалын багц дүрэм”-д нийцүүлэн

- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам,
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хорооны ажиллах журам,
- Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам,
- Бусад шаардлагатай дүрэм журмыг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулна.

Компанийн үйл ажиллагаатай холбогдох бусад дүрэм, журмын төсөлд санал өгөх, компанийн үйл ажиллагаа, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр ач холбогдолтой зохицуулалт тусгуулах чиглэлээр Сангийн яам, СЗХ, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлтэй нягт хамтран ажиллана.

Хүрэх үр дүн

Компани үйл ажиллагаагаа хэвийн явуулах хууль, эрх зүйн орчин сайжирсан байна.

V. ДААТГАЛЫН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ

5.1. АШГИЙН ЗОРИЛТ

Үндэсний давхар даатгал ХК нь 2022-2026 онд даатгалын орлогыг жил бүр 20 хувиар өсгөх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, дотоодын даатгагчдын олон улсын давхар даатгагчид шилжүүлж чаддаггүй бага үнэлгээтэй, олон хийгддэг бүтээгдэхүүнийг багцлан давхар даатгах зэргээр 2026 онд 23.7 тэрбум төгрөгт хүргэх зорилт тавиад байна. Стратегийн ач холбогдол бүхий бизнесийн бүтээгдэхүүний тэргүүлэх чиглэлд МИД болон гамшгийн даатгал, хөрөнгө, хариуцлага, авто тээврийн хэрэгсэл /тусгай зориулалтын болон хүнд машин механизмын даатгал/, агаарын хөлгийн даатгалын хэлбэрүүд орж байна. Эдгээр даатгалын хэлбэрүүд болон дор дурдсан даатгалын хэлбэрийн хүрээнд даатгалын бүтээгдэхүүний бизнесийн өсөлтийг хангаж ажиллах зорилтыг барьж ажиллана.

Үүнд:

- Мал амьтдын даатгал
- Газар тариалангийн даатгал
- Хөрөнгийн даатгал
- Барилга угсралтын даатгал
- Хариуцлагын даатгал
- Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
- Ачааны даатгал
- Агаарын хөлгийн даатгал

- Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал
- Авто тээврийн хэрэгслийн даатгал
- Санхүүгийн даатгал
- Зээлийн даатгал
- Гамшгийн даатгал
- Даатгагчийн баталгаа
- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ

Компанийн стратегийн голлох бүтээгдэхүүн МИД-ын хураамжийн орлого 2022 онд 1.5 тэрбум төгрөгт хүрч, 2024 он гэхэд 2021 оны үзүүлэлтээс 19 хувиар өсөж 1.8 тэрбум төгрөг болохоор төлөвлөж байна.

Бусад даатгалын бүтээгдэхүүний хувьд факультатив давхар даатгалын гэрээгээр 2023 онд нийт 3.2 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлогыг төвлөрүүлнэ. Үүнээс хөрөнгийн даатгал 37 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 25 хувь, бусад даатгалын хэлбэрүүд 38 хувийг эзэлнэ.

Гэрээт давхар даатгалын хүрээнд 5 тэрбум төгрөг хүртэлх хариуцлага бүхий 2-оос 3 дотоодын даатгагчдын гэрээт давхар даатгалын гэрээнд 50-аас 100 хувь, 5 тэрбум төгрөгөөс дээш хариуцлага бүхий даатгагчдын гэрээнд 5-аас 30 хувиар оролцох төлөвлөгөөтэй байна.

Хүснэгт 4. Даатгалын хураамжийн орлогын төсөөлөл /2022-2026 он/

	2022	2023	2024	2025	2026
Гэнэтийн осол	142.15	42.70	564.41	629.41	1,008.09
Хөрөнгө	1,561.11	1,873.34	4,164.93	9,210.96	9,762.16
Тээврийн хэрэгсэл	1,250.21	1,500.25	182.22	297.94	311.72
Ачаа	103.57	124.29	200.27	331.97	351.63
Барилга угсралт	275.09	330.11	867.81	1,444.83	1,536.39
Газар тариалан	-	-	186.48	188.34	190.23
Мал амьтан	1,492.82	1,643.60	1690.26	1845.07	1937.32
Агаарын хөлгийн их бие	196.54	235.85	606.02	648.68	667.34
Жолоочийн хариуцлага	-	-	6.25	3.47	3.69
Хариуцлага	345.43	414.51	900.51	1,481.74	1,559.22
Санхүү	171.23	180.48	183.93	200.78	210.82
Зээл	30.00	36.00	-	-	-
Даатгагчийн баталгаа	150.00	205.00	229.65	250.68	263.22
Агаарын хөлгийн хариуцлага	28.82	34.58	1,071.82	1,208.79	1,303.30
Газар хөдлөлт /гамшгийн даатгал/	-	-	-	4,523.19	4,634.08
Нийт	5,746.97	6,620.71	10,854.56	22,265.85	23,739.21

5.2. МАЛ АМЬТДЫН ДААТГАЛЫН ХЭЛБЭР

Зуд болон бусад гэнэтийн эрсдэлээс малчдын амьдралын баталгааг хамгаалах зорилгоор Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр МИД төслийг 10 жилийн турш амжилттай хэрэгжүүлжээ. МИД нь нэгж малчны малын хорогдлоор бус сумын хэмжээнд малын хорогдлын индекс гаргаж, даатгалын хохирол, нөхөн төлбөрийн хувь хэмжээг тооцоолдог онцлогтой. МИД нь Монгол Улс төдийгүй дэлхийн мал аж ахуйд анх удаагаа хэрэгжсэн даатгалын шинэлэг хэлбэр юм.

МИДТ нь 2005 оноос Баянхонгор, Увс, Хэнтий аймагт анхлан хэрэгжиж, 2009 оноос эхлэн жил бүр аймгийнхаа тоог нэмэх замаар 2012 оноос үндэсний хэмжээд хэрэгжиж эхэлсэн. 2015 оноос МИД-ын үйл ажиллагааг Үндэсний давхар даатгал ХК үргэлжлүүлэн амжилттай хэрэгжүүлж байна.

2022 оны МИД-ын борлуулалтад Ард даатгал ХК, Бодь даатгал ХК, Монгол даатгал ХК, Монре даатгал ХХК, Миг даатгал ХХК, Мөнх даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК даатгалын компаниуд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл, мөн зуучлалаар ажиллаж буй Төрийн банк, Хаан банк 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ны өдөр хүртэл хүртэлх хугацаанд 27,456 малчинтай МИД-ын гэрээг байгуулж, 3 тэрбум 911 сая төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна.

График 16. МИД-ын бүтээгдэхүүний хураамжийн орлого /сая төгрөгөөр/





График 17. МИД-ын хураамжийн орлого болон нөхөн төлбөр /2006-2022 он/



МИД хэрэгжсэн 16 жилийн хугацаанд давхардсан тоогоор 265,947 орчим малчин өрхийн 56.2 сая толгой малыг даатгалд хамруулж, 27.0 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлжээ. Эдгээрээс 45,849 малчин өрх нийт 8.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр авч, энэхүү даатгалын ач тусыг малчид амьдрал дээр бодитойгоор хүртээд байна.

2023 оноос МИД-ын борлуулалтыг нэмэгдүүлэх, малчдад хүрч үйлчлэх зорилгоор борлуулалтын шинэ сувгийг нэвтрүүлж, киоск болон пос машинаар МИД-ын гэрээг байгуулах боломжийг бүрдүүлж, бэлтгэл ажлыг хийгээд байна. Мөн цаашид цахимаар даатгуулах нөхцөлийг бүрдүүлэхээр даатгалын компаниудтай хамтран ажиллаж байна. 2022-2026 онд МИД-ын борлуулалтыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлж малчны төлөх хураамжийг 5 тэрбум, МИД-ын давхар даатгалын хураамжийг 1.8 тэрбум төгрөгт хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Хүснэгт 5. МИД-ын даатгалын үнэлгээ, ҮДД ХК-ийн хариуцлагын дээд хэмжээ

	2022 он /төгрөг/	2023 он /төгрөг/	2024 он /төгрөг/	2025 он /төгрөг/	2026 он /төгрөг/
Даатгалын хураамжийн орлого	1,477,816,704	1,625,598,374	1,690,265,558	1,845,067,106	1,937,320,461
Даатгалын үнэлгээ	135,302,309,695	148,832,540,664	163,715,794,731	180,087,374,204	198,096,111,624

Гарч					
болзошгүй хамгийн их хохирол	16,299,356,698	17,929,292,367	19,722,221,604	21,694,443,764	23,863,888,140

5.3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ХЭЛБЭР

Улаан буудайн даатгал

Үндэсний давхар даатгал ХК нь газар тариалангийн салбарт учирч буй эрсдэлийг бууруулах зорилгоор улаан буудайн даатгалыг 2016 оноос эхлэн туршилтын журмаар хэрэгжүүлж, 2016-2019 оныг хүртэлх хугацаанд уламжлалт даатгалын зарчмаар “Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал”-ыг хэрэгжүүлсэн. Туршилтын үр дүнгээс харахад даатгуулагч хангалтгүй хамрагдсан бөгөөд оролцогч талуудад дараах хүндрэл бэрхшээлүүд гарсан. Үүнд:

- Даатгалын компаниуд тариан талбай дээр очиж газар дээрх хяналт шалгалт хийх, хохирлыг үнэлэх зорилгоор 4-5 удаа очиж байгаа тул үйл ажиллагааны зардал маш өндөр байна.
- Хохирол үнэлгээг хийхэд цаг хугацаа, мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай байсан.
- Улаан буудайн даатгалын хувьд өндөр эрсдэлтэй, даатгалын хураамжийн хувь өндөр байгаа тул тариаланчдад даатгалын хураамжийг шууд төлөх бэлэн мөнгө байхгүй байна.
- Ихэнх тариаланчид банкны зээлтэй төдийгүй төрийн дэмжлэгийг харсаар байна.

Дээрх асуудлуудад үндэслэн 1970 оноос олон улсад хэрэгжүүлж эхэлсэн цаг уурын үзүүлэлтүүдэд үндэслэсэн индексжүүлсэн даатгалын хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж 2020 онд “Улаан буудайн индексжүүлсэн даатгал”-ын бүтээгдэхүүнийг хэрэгжүүлсэн. Улаан буудайн индексжүүлсэн даатгал гэж даатгуулагчид учирсан бодит хохирол бус, даатгалын гэрээний хугацаанд багийн хэмжээнд ургамлын ургалтын индекс /NDVI/ буурсан тохиолдол нөхөн төлбөр олгох даатгал юм. 2020 онд хэрэгжүүлсэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Шилжилтийн эдийн засгийн хөдөө аж ахуйн хөгжлийн Леибниц Институттай “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, гэрээний хүрээнд тус институт нь Монгол Улсын тариалангийн бүс нутгийн ургамлын индексийн бүхий л тооцооллыг хийж байна.

Цаашид Монгол Улсад тохиромжтой индексжүүлсэн даатгалыг улам боловсронгуй болгон хэрэгжүүлэх, газар тариалангийн даатгалд төрийн оролцоог нэмэгдүүлж Тариалангийн даатгалын хуулийн төслийг боловсруулан батлах нь зүйтэй байна. Хуулийн төслийн гол зарчим нь улсын төсвөөс тариалан эрхлэгчийн даатгалын хураамжийг 50 хувиас багагүйгээр дэмжих, нөхөн төлбөр олгох, тариалангийн даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны тодорхой хэсгийг санхүүжүүлэх зорилго бүхий сан байгуулах юм. Бид хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд идэвх санаачилгатай ажиллах зорилт тавьж байна.

Хүснэгт 6. Улаан буудайн даатгалын үнэлгээ, ҮДД ХК-ийн хариуцлагын дээд хэмжээ

Улаан буудайн даатгал	2022-2026 он /төгрөг/
-----------------------	--------------------------

Даатгалын хураамжийн орлого	50,000,000
Даатгалын үнэлгээ	1,395,936,684
Гарч болзошгүй хамгийн их хохирол	252,089,923

5.4. ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ

Монгол Улсын Засгийн газар Олон Улсын Хөгжлийн Ассоциатай хамтран “Экспортыг дэмжих төсөл”-ийг уул уурхайн бус салбарын ЖДҮ эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх, Ковид-19 цар тахлын үр нөлөөг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж байна. Төслийн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс төслийг тус бүрдээ бие даасан зорилт бүхий дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгон зохион байгуулж Үндэсний давхар даатгал ХК болон Төсөл хэрэгжүүлэх нэгж хэрэгжүүж байна. “Экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх” бүрэлдэхүүн хэсгийг Үндэсний давхар даатгал ХК хэрэгжүүлж байгаа төслийн үр дүнд экспортын зээлийн бүрэн эргэлтийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхэд бэлэн боллоо.

Бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, борлуулах хүрээнд Бодь даатгал ХК болон Миг даатгал ХХК-тай хамтран ажиллах ба тус компаниудтай давхар даатгалын мастер гэрээ байгуулан, СЗХ-нд экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр бүртгүүлсэн.

Үндэсний давхар даатгал ХК нь СКОР давхар даатгалын компанитай экспортын худалдааны зээлийн хувь тэнцүүлсэн давхар даатгалын гэрээг байгуулсан ба гэрээний дагуу олон улсын давхар даатгагчид гэрээний хариуцлага болон хураамжийн 80 хувийг шилжүүлэх ба давхар даатгуулагч буюу Үндэсний давхар даатгал ХК 20 хувийг хариуцна. Олон улсын худалдан авагчдын санхүүгийн шинжилгээг гүйцэтгэхдээ салбартаа тэргүүлэгч Парис хотод төвтэй Тинүбү Скуэр компанийн туршлагатай эрсдэлийн шинжээчидтэй хамтран ажиллахаар хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Төслийн хүрээнд экспортын зээлийн даатгалд

- Бүрэн эргэлтийн даатгал
- Худалдан авагчийн 1 гүйлгээний даатгал
- Банкны мастер гэрээ

зэрэг 3 бүтээгдэхүүнийг борлуулах бөгөөд Хүснэгт 6-д 2022-2026 оны борлуулалтыг төлөвлөгөөг харууллаа.

Хүснэгт 7. Даатгалын төсөөлөл (2022-2026 он)

Он	Гэрээний тоо	Хамрах хувь	Төлөвлөж буй хураамжийн дүн
2022	10	0.02%	30,000,000
2023	15	0.03%	33,000,000
2024	20	0.04%	36,300,000
2025	25	0.05%	39,930,000
2026	30	0.06%	43,923,000

5.5. ФАКУЛЬТАТИВ ДАВХАР ДААТГАЛ

МИД, эрчимжсэн мал аж ахуй болон газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнээс бусад даатгалын бүтээгдэхүүний факультатив давхар даатгалын гэрээгээр 2023 онд нийт 3.66 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлогыг төвлөрүүлнэ.

Хүснэгт 8. Бусад даатгалын бүтээгдэхүүний ҮДД ХК-ийн хураамж

№.	Даатгалын хэлбэр	ҮДД ХК-ийн хураамж /төгрөг/
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	20,669,088
2	Хөрөнгийн даатгал	1,417,863,243
3	Авто тээврийн хэрэгсэл	941,540,598
4	Ачаа тээврийн даатгал	60,000,000
5	Барилга угсралтын даатгал	240,013,329
6	Агаарын хөлгийн даатгал	235,846,426
7	Хариуцлагын даатгал	300,249,448
8	Санхүүгийн даатгал	173,000,000
9	Зээлийн даатгал	36,000,000
10	Даатгагчийн баталгаа	205,000,000
11	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	34,578,961
Нийт		3,664,761,093

Даатгалын орлогын төлөвлөгөөг гаргахдаа хүлээж чадах нийт эрсдэлийн дээд хязгаарыг тооцоолсон бөгөөд даатгалын хураамжийн 50 хувийг үйл ажиллагааны зардал болон ашиг гэж үзвэл үлдсэн 50 хувийг нөхөн төлбөрт зарцуулах боломжтой буюу зорилтот алдагдлын харьцаа нь 50 хувь юм. Нөхөн төлбөр нь нийт хураамжийн 50 хувьтай тэнцүү үед хамгийн ихдээ хэр хэмжээний даатгалын үнэлгээ буюу хариуцлагаас тухайн хэмжээний нөхөн төлбөр гарч болохыг тооцоолохын тулд нөхөн төлбөр, даатгалын үнэлгээний харьцааг ашигласан. Даатгалын зах зээлийн нөхөн төлбөр, даатгалын үнэлгээний дундаж харьцаа дээр тулгуурлан даатгалын гэрээгээр хүлээх хариуцлага буюу нийт үнэлгээний дээд хязгаарыг хэлбэр тус бүрээр таамаглалаа.

Даатгалын нэг гэрээгээр хүлээх хариуцлагыг төлөвлөсөн нийт гэрээний тоонд хувааж гаргав. Энэхүү төлөвлөгөөгөөр хүлээж болох эрсдэлийн дээд хэмжээг "Үндэсний давхар даатгал ХК-ийн эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлал"-ын 3.1 болон 3.2-т заасны дагуу шалгахад даатгалын эрсдэл нь зохимжтой хэмжээнд байна.

Хүснэгт 9. Хүлээж чадах нийт эрсдэлийн дээд хязгаар болон даатгалын нэг гэрээгээр хүлээх дээд хэмжээ /2022 он/

№	Даатгалын хэлбэр	Даатгалын гэрээгээр хүлээх хариуцлага буюу нийт үнэлгээний дээд хязгаар /төгрөг/	Гэрээний тоо	Нэг гэрээний даатгалын үнэлгээний дээд хязгаар /төгрөг/	Давхар даатгагчид шилжүүлэх эрсдэлийн хэмжээ
1	Гэнэтийн осол	46,829,358,885	5	9,365,871,777	-
2	Хөрөнгө	3,091,204,611,265	42	73,600,109,792	533,386,749,509
3	Тээврийн хэрэгсэл	179,533,393,843	14	12,823,813,846	-
4	Ачаа	192,199,755,239	11	17,472,705,022	-
5	Барилга угсралт	516,091,808,162	12	43,007,650,680	-
6	Мал амьтан	50,425,652,368	8	6,303,206,546	-
7	Агаарын хөлөг	407,077,929,477	3	135,692,643,159	81,415,585,895
8	Хариуцлага	1,317,207,249,104	17	77,482,779,359	263,441,449,821
9	Санхүү	52,602,753,806	15	3,506,850,254	1,836,780,800
10	Зээл	6,338,265,505	5	1,267,653,101	-
11	Итгэлцэл	63,107,298,920	30	2,103,576,631	-
12	Агаарын хөлгийн хариуцлага	10,731,091,705,726	3	3,577,030,568,575	2,146,218,341,145

5.6. ГЭРЭЭТ /ТРИТИ/ ДАВХАР ДААТГАЛ

Гэрээт давхар даатгалын хүрээнд 5 тэрбум төгрөг хүртэлх хариуцлага бүхий 3-аас 5 дотоодын даатгагчдын гэрээт давхар даатгалын гэрээнд 50-аас 100 хувь, 5 тэрбум төгрөгөөс дээш хариуцлага бүхий даатгагчдын гэрээнд 5-аас 30 хувиар оролцох төлөвлөгөөтэй байгаа бөгөөд нийт гэрээт давхар даатгалын хураамжийг 2023 онд 1.3 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 10. Гэрээт давхар даатгалын гэрээний хураамжийн орлого /2023 он/

№	Даатгалын хэлбэр	ҮДД ХК-ийн хураамж /төгрөг/
1	Гэнэтийн ослын даатгал	22,028,575
2	Хөрөнгийн даатгал	455,473,398
3	Авто тээврийн хэрэгсэл	558,709,852

4	Ачаа тээврийн даатгал	64,287,378
5	Барилга угсралтын даатгал	90,097,738
6	Хариуцлагын даатгал	114,261,255
7	Санхүүгийн даатгал	7,481,295
Нийт		1,312,339,491

Хүснэгт 11. Хүлээж чадах нийт эрсдэлийн дээд хязгаар болон даатгалын нэг гэрээгээр хүлээх дээд хэмжээ /2022 он/

№	Даатгалын хэлбэр	Давхар даатгалын хураамж /төгрөг/	Дундаж харьцаа	Даатгалын гэрээгээр хүлээх хариуцлага буюу нийт үнэлгээний дээд хязгаар /төгрөг/	Нэг гэрээний даатгалын үнэлгээний дээд хязгаар /ам.доллар/
1	Гэнэтийн осол	22,028,575	0.04%	22,028,575	1,000,000
2	Хөрөнгө	455,473,398	0.03%	455,473,398	10,000,000
3	Тээврийн хэрэгсэл	558,709,852	0.44%	558,709,852	1,000,000
4	Ачаа	64,287,378	0.03%	64,287,378	5,000,000
5	Барилга угсралт	90,097,738	0.04%	90,097,738	10,000,000
6	Хариуцлага	114,261,255	0.02%	114,261,255	5,000,000
7	Санхүү	7,481,295	0.19%	7,481,295	10,000,000

VI. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИЛГО, УДИРДЛАГА

Үндэсний давхар даатгал ХК-ийн хөрөнгө оруулалтын мөнгөн хөрөнгийг холбогдох хууль, СЗХ-ны “Даатгалын багц дүрэм”-ийн дагуу удирдан, эрсдэлийг тараан, өгөөжийг зорилтот түвшинд байлгахад хөрөнгө оруулалтыг тэнцвэртэйгээр төлөвлөхөд оршино. Иймээс бид даатгалын салбарын онцлогтой уялдсан, мөн компанийн өдөр тутмын үйл ажиллагааны мөнгөн урсгалд нөлөөлөхгүй тогтмол орлогоо бууруулахгүйгээр хөрөнгө оруулалт хийхийг зорино.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

Компанийн хувьд нийт хөрөнгө оруулалтын багц нь хадгаламжийн бүтээгдэхүүнд төвлөрдөг. Мөнгөн хөрөнгийг байршуулахдаа Сангийн сайдын тушаал чиглэлийн дагуу “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох, хяналт тавих журам”-ын дагуу 1, 2 дугаар бүлгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй системийн нөлөө бүхий банкнуудад байршуулдаг.

Даатгалын салбарын онцлог нь гэнэтийн хүчин зүйлийн эрсдэлийг хүлээдэг учир нөөц сангийн хөрөнгө нь хангалттай бөгөөд хөрвөх чадвар сайтай байснаар компанийн төлбөрийн чадварыг хангадаг. Иймд бидний хувьд баримтлах гол суурь нь банкны

хадгаламж болон хөрвөх чадвар сайтай богино хугацаат хөрөнгө оруулалт, өгөөж өндөртэй урт хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд төвлөрөх юм.

Хөрөнгө оруулалт хийхэд баримтлах бодлого

Банкны салбарын үр өгөөж жил ирэх тутам буурч байгаатай холбоотойгоор хөрөнгө оруулалтын нэг хэлбэрээс хамааралтай байдлыг багасгах, мөн СЗХ-оос хөрөнгийн зах зээлийг дэмжих үйл ажиллагаа явуулж байгаатай холбогдуулан хууль, журамд нийцсэн хөрөнгө оруулалтын урт болон богино хугацааны шинжилгээ судалгаа, тооцоолол хийж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааны мөнгөн урсгалд нөлөөлөхгүй, тогтмол орлогоо бууруулахгүйгээр хөрөнгө оруулалтын чиглэлээ тодорхойллоо.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны явц:

- Хөрөнгө оруулалтын хэлбэрээ сонгох /ҮДД ХК-ийн шинэчилсэн "Хөрөнгө зохицуулах журам"-ын дагуу/,
- Сонгосон санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах мөнгөн дүн болон хэрхэн тараан байршуулахаа тодорхойлох.

Хөрөнгө оруулалтын өгөөжийг хуваарилах:

- Хөрөнгө оруулалтын өгөөжийн дийлэнх хэсэг болох хадгаламжийн хүүгийн орлогоор мөнгөн хөрөнгөө нэмэгдүүлэх,
- Хөрөнгө оруулалтын өгөөжийн үлдэх хэсгээр бусад хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах дүнг нэмэгдүүлснээр компанийн санхүүгийн үйл ажиллагааг чадавхжуулна.

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн тайлан гаргах:

- Гүйцэтгэлийг төлөвлөгөөний дагуу улирал бүр гарган танилцуулах,

Хөрөнгө оруулалтын ангилалд өөрчлөлт орох тохиолдолд төлөвлөж буй хөрөнгийг дахин тэнцвэржүүлнэ.

6.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2022-2026 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

Үндэсний давхар даатгал ХК-ийн хөрөнгө оруулалтын нийт мөнгөн хөрөнгө нь 2022 оны байдлаар 54.98 тэрбум төгрөг байсан бөгөөд дараах сангуудад хуваагдаж байна. Үүнд:

- Дүрмийн сан 24.5 тэрбум төгрөг,
- Алдагдлаас хамгаалах сан 19.0 тэрбум төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны орлогын өгөөж 0.61 тэрбум төгрөг,
- Орлогод тооцоогүй хураамжийн нөөц 1.70 тэрбум төгрөг,
- Даатгалын нөөц сан /Нөхөн төлбөрийн нөөц сан/ 9.17 тэрбум төгрөг,
- Хамтын эрсдэлийн сан 1.9 тэрбум төгрөгөөс бүрдэж байна.


Хамтын эрсдэлийн санг "Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль"-ийн 4.1.13-д заасны дагуу даатгуулагчид учирсан хохирлыг нөхөн төлөх үүргийг хариуцахаар хэд хэдэн даатгагч хамтран байгуулсан. Тус хуулийн 22.3.3-т заасны дагуу хамтын эрсдэлийн санг

удирдах бүрэн эрх нь давхар даатгалын компанийн Гүйцэтгэх захиралд олгосон байдаг тул компанийн санхүүгийн байдлын тайланд тусгасан болно.

2023-2026 оны хөрөнгө оруулалтын орлогын төсөөлөлд нэмж хувьцаа гаргаснаар татан төвлөрүүлэх хөрөнгийн 90 хувийг хөрөнгө оруулалтын багцыг нэмэгдүүлэхээр тооцов.

Хөрөнгө оруулалтыг урьдчилсан байдлаар нийт мөнгөн хөрөнгийн 95-75 хувийг арилжааны банканд, 5-25 хувийг бусад хөрөнгө оруулалтын хэлбэрт байршуулахаар төлөвлөлөө.

График 18. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө



Хөрөнгө оруулалтын орлого

Хөрөнгө оруулалтын орлогын өгөөжийг тооцохдоо арилжааны банк болон хөрөнгө оруулалтын бусад сувгийн өгөөжийн хэмжээг дараах байдлаар тооцов.

Хүснэгт 12. Урьдчилан тооцсон дундаж хүүгийн түвшин

№	Хөрөнгө оруулалтын хэлбэр	2023	2024	2025	2026
1	Арилжааны банканд тооцсон хүүгийн түвшин	9.46%	10.81%	10.81%	9.81%
2	Хөрөнгө оруулалтын бусад суваг тооцсон хүүгийн түвшин	12.50%	13.81%	13.81%	12.81%

Хүснэгт 13. Хөрөнгө оруулалтанд байршуулах дүн /тэрбум төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын хэлбэр	2022 оны нийт багцын дүн	2023	2024	2025	2026
1	Даатгалын орлогоос нөөц санг нэмэгдүүдэх дүн	54.98	0.04	0.04	2.92	2.99

2	Хөрөнгө оруулалтын орлогоос нэмэгдүүлэх дүн	0.00	2.76	2.52	2.76
3	IPO татан төвлөрүүлэх дүн	9.36			
	Нийт багцын дүн	64.38	67.15	69.78	70.09

Хүснэгт 14. Хөрөнгө оруулалтын өгөөж /тэрбум төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын хэлбэр	багцад эзлэх хувь	2023 оны хүүгийн орлого	2024 оны хүүгийн орлого	2025 оны хүүгийн орлого	2026 оны хүүгийн орлого
1	Арилжааны банкинд байрших дүн	95%	5.79	6.89	7.16	6.53
2	Хөрөнгө оруулалтын бусад сувагт байрших	5%	0.40	0.46	0.48	0.45
		100%	6.19	7.36	7.65	6.98

Хөрөнгө оруулалт хийхдээ СЗХ-ны даатгалын багц дүрмийн дагуу хадгаламж, ЗГҮЦ, МХБ-ийн 1, 2-р ангиллын үнэт цаас, компанийн бонд, үл хөдлөх, хөрөнгө оруулалтын нээлттэй, хаалттай сангийн нэгж эрх гэх мэт санхүүгийн хэрэгслүүдэд байршуулж, хөрөнгө оруулалтын өгөөжийг дунджаар 17.0-18.8 хувиар өсгөхөөр төлөвлөж байна.

VII. САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Санхүүгийн төлөвлөгөөг даатгалын орлого, түүнтэй холбогдох зардал, хөрөнгө оруулалтын өгөөж болон компанийн үйл ажиллагааны зардал зэрэгт үндэслэн 2022-2026 оны төсөөллийг гаргасан.

2024 онд хураамжийн орлого өссөн хэдий ч компанийн цэвэр ашиг буурч байгаа нь компанийн хүлээх хариуцлагын хэмжээ ихсэж, нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотой. Санхүүгийн төсөөллийн 2.2-т тусгасан “Нөхөн төлбөрийн нөөц сангийн зардал”-ийн дүнгээр хохирлын нөөц санг нэмэгдүүлнэ. Нөөц сан нь компанийн шууд зардал биш бөгөөд СЗХ-оос баталсан Даатгалын багц дүрмийн дагуу бүрдүүлэх ёстой ба сангийн хэмжээ хангалттай байх тусам компанийн эрсдэл даах чадвар өндөр байна.

Хүснэгт 15. Санхүүгийн төсөөлөл 2022-2026 он /сая төгрөг/

		2023	2024	2025	2026
1	Орлогын дүн	12,808.72	18,211.41	29,911.28	30,717.94
1.1	Нийт даатгалын хураамж	6,620.71	10,854.56	22,265.85	23,739.21
1.2	Хөрөнгө оруулалтын орлого	6,188.01	7,356.85	7,645.43	6,978.73
1.3	Бусад орлого				
2	Даатгалын зардал	4,505.57	8,662.78	13,081.30	11,312.05
2.1	Нийт төлсөн нэхэмжлэл (нөхөн төлбөр)	599.38	1085.45	3,339.87	3,560.88
2.2	Нөхөн төлбөрийн нөөц сангийн зардал	953.18	2,957.97	3,114.46	701.404
2.3	Гадаад шилжүүлэг (ОУ-ын ДД-ын зардал)	2,686.18	4,306.15	6,298.10	6,704.46
2.4	Даатгалын гэрээний зардал	266.83	313.21	328.87	345.31

3	Үйл ажиллагааны зардлын дүн	4,047.62	4,456.38	4,895.01	5,377.52
3.1	Бараа үйлчилгээний зардал	2,677.46	2,945.21	3,239.73	3,563.71
3.2	Бараа үйлчилгээний бусад зардал	1,310.15	1,441.17	1,585.28	1,743.81
3.3	Татаас ба урсгал шилжүүлэг	60	70	70	70
4	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,255.53	5,092.25	11,934.97	14,028.37
5	Орлогын албан татварын зардал	618.8	735.69	764.54	697.87
6	Татварын дараах ашиг (алдагдал)	3,636.73	4,356.57	11,170.42	13,330.49

Хүснэгт 16. Балансын бүтэц - Хөрөнгө 2023-2026 он /сая төгрөг/

№	Үзүүлэлт	2023	2024	2025	2026
	ХӨРӨНГӨ				
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	1,000.00	800.00	950.00	900.00
	Даатгалын авлага болон бусад авлага	499.13	554.04	614.98	682.63
	Урьдчилж төлсөн зардал	50.00	30.00	30.00	40.00
	Бараа материал	6.42	7.06	7.76	8.54
	Давхар даатгалын хойшлогдсон хураамж	757.61	1,242.09	2,547.90	2,716.49
	Хөрөнгө оруулалт	72,913.23	81,840.18	99,568.12	114,200.23
	Эргэлтийн хөрөнгийн дүн	75,226.40	84,473.37	103,718.76	118,547.90
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ				
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	331.13	298.01	268.21	241.39
	Биет бус хөрөнгө /Цэвэр/	589.32	530.39	477.35	429.62
	Ашиглах эрхтэй хөрөнгө	44.52	-	-	-
	Хойшлогдсон татварын хөрөнгө				
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	964.97	828.40	745.56	671.01
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	76,191.36	85,301.77	104,464.32	119,218.90

Хүснэгт 17. Балансын бүтэц - Өр төлбөр ба Эздийн өмч 2023-2026 он /сая төгрөг/

№	Үзүүлэлт	2023	2024	2025	2026
---	----------	------	------	------	------

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
ӨР ТӨЛБӨР				
Санхүүгийн өр төлбөр	-	-	-	-
Санхүүгийн бус өр төлбөр	-	-	-	-
Хойшлогдсон татварын өглөг	-	-	-	-
Орлогд тооцоогүй хураамжийн нөөц	2,714.49	4,450.37	9,129.00	9,733.08
Хамтын эрсдэлийн сан	2,113.20	2,173.19	2,372.23	2,490.84
Эрсдэлээс хамгаалах сан	10,122.89	13,080.86	16,195.32	16,896.72
Өр төлбөрийн нийт дүн	14,950.58	19,704.42	27,696.55	29,120.64
ЭЗДИЙН ӨМЧ				
Эзэмшигчийн өмч	30,625.00	30,625.00	30,625.00	30,625.00
Эздийн өмчийн бусад хэсэг /НТК/	4,879.26	4,879.26	4,879.26	4,879.26
Алдагдлаас хамгаалах сан	19,000.00	19,000.00	19,000.00	19,000.00
Хуримтлагдсан ашиг	6,736.52	11,093.09	22,263.51	35,594.00
Эздийн өмчийн дүн	61,240.79	65,597.36	76,767.78	90,098.27
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	76,191.36	85,301.77	104,464.32	119,218.90

VIII. МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний давхар даатгал ХК-ийн маркетингийн стратеги нь компанийн үйл ажиллагаа, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, даатгалын тэр дундаа давхар даатгалын талаарх мэдлэг мэдээллийг олон нийт, харилцагч байгууллагуудад өгөхөд оршино.

Компанийн үйл ажиллагаа, онцлох үйл явдал болон шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний тухай нийтлэл, шторкыг тухай бүр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, ААН-үүдэд сурталчлахын зэрэгцээ эерэг сурталчилгаа хийж, компанийн таатай дүр төрхийг бий болгох замаар олон нийттэй харилцах харилцаагаа сайжруулна. Компани өөрийн цахим хуудсыг тогтмол шинэчлэн, бусад олон нийтийн мэдээллийн хуудсаар даатгалын салбарын тухай болон даатгалын бүтээгдэхүүний талаар сонирхолтой нийтлэл бичиж түгээнэ.

Компанийн хувьд МИД, экспортын зээлийн даатгалд тусгайлан төлөвлөгөө боловсруулан тухайн бүтээгдэхүүний ач холбогдол, үнэ цэний талаар гүнзгий ойлголтыг өгснөөр бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх хүлээлт үүсгэж, борлуулалтыг нэмэгдүүлнэ. Зах зээлийг буюу даатгуулагчдыг сегментлэн маркетингийн арга хэрэгслийг сонгох юм.

Малын индексжүүлсэн даатгал

ҮСХ-ны тооллогоор Монгол Улсад нийт 181,000 малчин өрх байгаагаас МИД-д 19.1 хувь нь буюу 34,709 малчин өрх даатгуулсан байна. Компани 2026 он гэхэд нийт малчин өрхийн 25 хувийг даатгах зорилготой бөгөөд аймаг, орон нутгаар бүсчлэн телевиз, хэвлэмэл материал, нүүр тулсан сурталчилгаагаар дамжуулан мөн борлуулалтын идэвхжүүлэлтийг хийнэ. МИД-ын маркетингийн идэвхжүүлэлтэд оролцогч даатгалын компаниуд болон зуучлагч банкууд тодорхой хэмжээнд хамтран ажиллах юм.

Хүснэгт 18. МИД-ын маркетингийн төлөвлөгөө

1. Телевизийн сурталчилгаа		
1	Нэвтрүүлэг ивээн тэтгэж, МИД-ыг сурталчлах	
1.1	Нэвтрүүлэг ивээн тэтгэх	Орон нутагт хамгийн өндөр үзэлттэй нэвтрүүлэгт ивээн тэтгэгчээр орж МИД-ын тухай сурталчлуулах
2	МИД-ын нэвтрүүлгийг цацах	
2.1	МҮОНРТ	Орон нутгийн малчдад хүрдэг хамгийн өндөр үзэлттэй сувгаар МИД-ын нэвтрүүлгийг цацах /20 минут гэж тооцов/
2.2	ТВ9	
2.3	Малчин ТВ	
3	МИД-ын реклам, шторк цацах	
3.1	МҮОНРТ Цагийн Хүрд нэвтрүүлгийн өмнө	Оргил цаг учир үзэлт өндөр, МИД-ын борлуулалтын үеэр ээлжлэн цацах /60 секунд гэж тооцов/
3.2	Малчин ТВ	
4	Орон нутагт өндөр үзүүлэлттэй нэвтрүүлгээр орох	
4.1	Монгол коммент нэвтрүүлгээр орох	Орон нутагт хамгийн өндөр үзүүлэлттэй уг нэвтрүүлэгт МИД-ын борлуулалтын үеэр өөрсдийн бэлдсэн мэдээг оруулах.
4.2	Малчин ТВ	Орон нутагт очин нэвтрүүлэг бэлтгэх, цацах
4.3	Монголын үндэсний радиотой хамтран ажиллах	МИДТөслийн үед явуулж байсан радио зохиолыг дахин гаргах /15 минут 5 нэвтрүүлэг, 2 ярилцлага/
4.4	Авто тээврийн үндэсний төвтэй хамтран ажиллах	Орон нутгийн чиглэлийн автобусны телевизээр шторкоо гаргах
2. Хэвлэмэл сурталчилгаа		
5	Сонин хэвлэх	
5.1	Борлуулалтын үеэр	МИД болон компанийн мэдээлэл бүхий сонин хэвлүүлэх
6	МИД-ын гарын авлага	
6.1	2023 оны борлуулалтын улирлаас өмнө	Хэвлэмэл материал тендер зарлах нь удаашралтай байгаагаас оны эхний саруудын хугацаа алддаг тул тухайн оны төсөвт ирэх жилийн борлуулалтаар тараах эхний материалыг хэвлэх
7	Бусад хэвлэн тараах материал	
7.1	Брошур хэвлэн тараах	Малчдад зориулсан, шинэ дизайн хийцтэй, өвөрмөц байдлаар хийх
7.2	МИД-ын постер бэлтгэх /Банк/	МИД-ын сурталчилгааны постер хийн оролцогч даатгалын компани болон банкуудын салбар, нутгийн удирдлагын ордон, сум багийн соёлын ордонд байршуулах
7.3	МИД-ын постер бэлтгэх /Киоск, пос/	
3. Орон нутгийн удирдлага, малчдыг идэвхжүүлэх		
8	Орон нутгийн удирдлагуудыг идэвхжүүлэх	

8.1	Сум орон нутагт идэвхжүүлэлт хийх, малчдад дэмжлэг үзүүлэх	Зорилтот аймаг, сумдын МИД хариуцсан ажилчдыг идэвхжүүлэх, зуд болон байгалийн хүчин зүйлийн улмаас малаа алдсан малчдад дэмжлэг үзүүлэх
9	Дижитал маркетинг	
9.1	Фейсбүүк цахим хуудсаар дамжуулан шторк цацах	Борлуулалтын үеэр 2 шторкыг төлбөрт сурталчилгаа байршуулан зөвхөн орон нутагт цацах.
9.2	Малчдад мессеж явуулах	МИД хэрэгжиж эхэлсэн бүх цаг үед даатгуулсан малчдад мессеж хүргүүлэх
4. Борлуулалтын урамшуулал, идэвхжүүлэлт		
10	Уралдаан зарлах	
10.1	Улсын тэргүүний салбар	Борлуулалтын дүн, өсөлтийн дүнгээрээ улсдаа тэргүүлсэн даатгалын компанийн салбарыг шалгаруулах
10.2	Аймгийн шилдэг салбар	21 аймгийг 4 бүс болгон хувааж уралдаан зарлан борлуулалтын дүн, өсөлтийн дүнгээрээ тэргүүлсэн даатгалын компанийн 4 салбарыг шалгаруулах
10.3	Банкны зуучлалын шилдэг салбар	Зуучлагч банкуудын салбар нэгжүүдээс тус бүр 1, нийт 2 салбарыг шалгаруулах

Экспортын зээлийн даатгал

Экспортын зээлийн даатгал Монгол Улсад шинэ бүтээгдэхүүн тул зорилтот даатгуулагчдад экспортын зээлийн даатгалын ач холбогдол, үнэ цэнийг түгээж гол салбар, бүс нутгуудад хүрч ажиллана. Үүний тулд дотоодын сүлжээ чухал үүрэгтэй тул хамтран ажиллаж буй даатгалын компани, арилжааны банкнуудын салбар бүрд хүрч ажиллах нь борлуулалтын сувгийг тэлэх үндсэн боломж юм.

Монгол Улс жилд ойролцоогоор 600 сая ам.долларын уул уурхайн бус бүтээгдэхүүн экспортолдог бөгөөд энэ нь нийт экспортын 11 хувийг эзэлж байна. Манай улсад уул уурхайн бус экспортыг ихэвчлэн ЖДҮ эрхлэгчид хийдэг тул жижиг, дунд үйлдвэрүүдэд онцгой анхаарал хандуулж ажиллана. Зах зээлийн судалгааны дагуу экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг эхний жилүүдэд хүргэх чухал салбарууд нь малын ноос ноолуур, мах байна.

Цогц сурталчилгааг ЖДҮ эрхлэгчид, томоохон ААН-үүд болон арилжааны банкнуудын хамт нэгдсэн байдлаар хийхээр төлөвлөсөн. Үүнд:

- **Зар сурталчилгаа:** Зорилтот экспортлогчдод хүрэх хэвлэл мэдээллийн сувгаар дамжуулан шинэ бүтээгдэхүүний сурталчилгааны компани ажлыг зохион байгуулна. Даатгалын компани болон Үндэсний давхар даатгал ХК-ийн танилцуулга, экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүний брошюр, постер, видео контент, нэвтрүүлэг гаргах нь экспортлогчид болон арилжааны банкуудыг уг даатгалын бүтээгдэхүүнийг худалдан авахад түлхэц болно.
- **Биечлэн борлуулалт хийх:** Биечлэн борлуулалт хийснээр үйлчлүүлэгчийн хэрэгцээг хурдан ажиглах, бүтээгдэхүүн үйлчилгээний саналд шуурхай өөрчлөлт, сайжруулалт оруулах боломж бүрдэнэ. Тус ажлын хүрээнд Үндэсний давхар даатгал ХК нь банк, оролцогч даатгалын компаниудын борлуулалтын ажилтны чадавхыг сайжруулж, даатгалын эрэлт хэрэгцээг таниулах, даатгалын гэрээ эзэмшигчийн төрөлд нийцүүлэн бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах чиглэлийн сургалтыг зохион байгуулна.
- **Олон нийттэй харилцах:** Зах зээлийн алсын харааг нэмэгдүүлэх, зээлийн

даатгалыг нэвтрүүлж, нутагшуулахын тулд Үндэсний давхар даатгал ХК нь салбар, салбарын тэргүүлэгч ААН, холбоод, МХАҮТ, эрдэмтэн, судлаачидтай хамтран Монгол Улсын экспортыг төрөлжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, санхүүгийн шийдлийн боломжуудын талаар хэлэлцүүлэг зохион байгуулан нийтэд хүргэх, мэдээлэх ажлуудыг зохион байгуулна. Мөн холбогдох хурал, чуулган, форумд оролцож ААН-үүдэд мэдээлэл хүргэж ажиллана.


- **Дижитал маркетинг:** Компани цахим хуудас, бусад олон нийтийн цахим хуудсуудаар дамжуулан харилцагчдад тогтмол мэдээлэл, заавар, зөвлөмж өгч ажиллана. Ингэхдээ контентийг экспортлогч, импортлогч, хөрөнгө оруулагч, арилжааны банк зэрэг зорилтот бүлгүүдийн хэрэгцээ тус бүрийг хангаж байхаар боловсруулна.

IX. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

9.1. КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үндэсний давхар даатгал ХК нь Андеррайтинг, бизнес хөгжлийн газар, Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар, Захиргаа, удирдлагын газар гэсэн 3 газар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.

Зураг 1. Байгууллагын бүтэц



Компанийн удирдлага, газар нэгжийн чиг үүрэг

Андеррайтинг, бизнес хөгжлийн газар:

1. Компанийн давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж, хөдөө аж ахуйн болон бусад даатгалын бүтээгдэхүүний давхар даатгах эрсдэлийн судалгаа, андеррайтинг хийж, үнийн санал боловсруулах, бүртгэх;
2. Давхар даатгалын гэрээ болон баталгааг даатгалын компаниудтай байгуулах, даатгалын компаниуд, зуучлагч банкууд болон бусад оролцогч талуудтай хамтарч ажиллах;
3. Олон улсын давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж, олон улсын давхар даатгалын гэрээ болон баталгааг байгуулах, бүртгэх;
4. Давхар даатгалын үйл ажиллагааны журам болон бусад холбогдох журмыг мөрдлөг болгон ажиллах;
5. МИД болон давхар даатгалын бүтээгдэхүүний программ хангамжийг хөгжүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах;
6. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээ хийх;
7. Олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

8. Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах
9. Компанийн маркетингийг хөгжүүлэх;

Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар:

1. Компанийн сангийн хөрөнгийг /МИД-ын хамтын эрсдэлийн сангаас бусад/ холбогдох зохицуулалтын хүрээнд удирдан зохион байгуулах, бүрдүүлэх, төлөвлөх, нөөц сангуудын байршлын тайланг гаргах;
2. Даатгалын үйл ажиллагаанд шаардагдах актуар тооцоолол хийх, актуар тайлан гаргах, судалгаа хийх;
3. Олон нийтэд шинээр нэмж үнэт цаас гаргах замаар компанийг нээлттэй хувьцаат компани болгох ажлыг зохион байгуулах;
4. Чанарын менежментийн тогтолцооны стандарт /ISO: 9001/-ыг нэвтрүүлэх;
5. Компанийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, холбогдох судалгааг боловсруулан тайлагнах;
6. Эдийн засаг, бизнесийн орчин болон хөрөнгө оруулалтын сувгийн судалгаа, санхүүгийн тайлангийн шинжилгээ хийх;
7. Нөхөн төлбөрийн тооцооллыг үнэн зөв хийж, нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;
8. Компанийн дотоод үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах;

Захиргаа, удирдлагын газар:

1. Компанийн хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн асуудлыг шийдвэрлэх;
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг хангах;
3. Компанийн худалдан авалтын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;
4. Компанийн цахим хуудас, цахим сурталчилгааг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
5. Компанийн архив, бичиг хэргийн ажлыг хариуцан зохион байгуулах;
6. Компанийн хууль эрх зүйн асуудлыг хариуцан зохион байгуулах;

Удирдлагын үүрэг хариуцлага

Гүйцэтгэх захирал:

Холбогдох хууль, дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

- Компанийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, зохицуулах, хянах замаар компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллана.
- Компанийн зорилт, стратеги, бодлого, хөтөлбөрийг тодорхойлох, ерөнхий удирдлага, чиглэлээр хангана.
- Компанийн төсөв боловсруулах, батлуулах, удирдах, зардлыг хянах, хүний нөөцийн болон санхүүгийн нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангана.

- Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах, үнэлэх, зөвлөмж, тайланг судлах, гадна талд байгууллагаа төлөөлнө.

9.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үндэсний давхар даатгал ХК-ийн эрхэм зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, бэлэн байгаа хүний нөөцийг үнэлэх, ирээдүйн хэрэгцээг тодорхойлох, түүнд хүрэхэд учирч болох эрсдэлийг тооцоолох, цаашилбал гүйцэтгэлд суурилсан бүтээлч байдал, чадварлаг, тогтвор суурьшилтай боловсон хүчин бий болгох замаар чадварлаг, мэргэшсэн, цомхон багийг бүрдүүлэхэд оршино.

Стратеги 1. Ажлын байрны хэрэгцээ шаардлагад нийцсэн чадварлаг, бүтээлч, сурч, хөгжих тэмүүлэлтэй, зөв хандлага бүхий хамт олныг бүрдүүлэх;

Хүрэх үр дүн: Ажлын байрны хэрэгцээ, шаардлагыг хангахуйц мэдлэг, ур чадвар бүхий хүний нөөцийг зохих албан тушаалд тухайн цаг үед нь зөв байршуулан хөгжүүлж, идэвхжүүлснээр мэдлэг, чадвар, идэвх санаачилга бүхий хүний нөөц бүрдэнэ.

Стратеги 2: Ажилтны нийгмийн баталгааг хангах, ажлын байрны орчныг сайжруулах;

Хүрэх үр дүн: Хүний нөөцийн нийгмийн баталгаа хангагдсанаар ажиллагчдын сэтгэл санаа өөдрөг, ажилдаа сэтгэл ханамжтай, итгэлтэй болж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэж, ажлын бүтээмж дээшилнэ.

Стратеги 3: Гүйцэтгэлийн зөв шударга үнэлгээ, цалин урамшууллын оновчтой системийг хэрэгжүүлэх;

Хүрэх үр дүн: Ажлын гүйцэтгэлийг оновчтой хэрэгжүүлснээр удирдлага ажиллагсдынхаа ажлын гүйцэтгэлийн талаар бодитой мэдээлэлтэй болж, улмаар ололт амжилтыг хөхиүлэн дэмжиж, шагнаж урамшуулах, алдаа дутагдлыг олж илрүүлэх, шалтгааныг тодорхойлж арилгах арга хэмжээ авах боломж бүрдэнэ.

Стратеги 4: Хүний нөөцийн дотоод эх үүсвэрээс төлөвлөлт хийх, гол ажилтныг тогтоон барих, залгамж халааг бэлтгэх зарчмыг хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Байгууллагын өндөр ур чадвар бүхий ажилтны тоо нэмэгдсэнээр хүний нөөцийн тогтвор суурьшил болон хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, залгамж халаа бэлтгэгдэж, албан тушаалын хийдэл арилж, байнгын нөөцтэй болж, ажилтны ажиллах идэвх нэмэгдэнэ.

Стратеги 5: Байгууллагын соёлыг бүрдүүлэх, эерэг уур амьсгалыг төлөвшүүлэх;

Хүрэх үр дүн: Эрч хүчтэй багийн ажиллагааг эрхэмлэсэн, нэгэн зорилго чиглэлд чиглэсэн бүтээлч хандлагатай хамт олон бий болно.

Х. ДҮГНЭЛТ

Үндэсний давхар даатгал ХК-ийн 2019-2021 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан компанийн үйл ажиллагааг өргөтгөх, малын индексжүүлсэн даатгалаас бусад даатгалын хэлбэрүүдэд давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх, андеррайтингийн бодлогоо боловсруулах, компанийн эрсдэлийн менежментийг сайжруулах, комплаенсын удирдлагын тогтолцоог бий болгох зорилгууд амжилттай хэрэгжсэн ба одоо компанийн хөгжлийг дараагийн үе шатанд авчрах шаардлага үүсэж байна.

Компанийн дотоод орчин буюу үйл ажиллагааны хүчтэй, сул талыг тодорхойлсон SWOT шинжилгээнээс харахад Үндэсний давхар даатгал ХК-ийн хувьд зах зээл дээр байр сууриа эзэлсэн, одоогийн байдлаар дотоодын өрсөлдөгч байхгүй зэрэг давуу талтай байна. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу компани ISO стандартыг нэвтрүүлж, олон улсын зэрэглэл тогтоолгож, даатгалын үйлчилгээг олон улсын жишгийн дагуу хийдэг болсноор харилцагч компаниуд, иргэдийг компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны чадавхад итгэх итгэлийг нэмэгдүүлэх юм.

Олон нийтэд нээлттэй компани болж, хувийн хэвшлээс хөрөнгө оруулалт татсанаар компанийн эрсдэл даах чадвар нэмэгдэхээс гадна компанийн засаглал, менежмент, сайжирч тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах, олон нийтэд чиглэсэн даатгалын шинэ тутам тогтолцоог бүрдүүлэн ажиллана.

Мөн хөрөнгө оруулалтын хүүгийн өгөөж цаашид ч буурах төлөвтэй байгаа энэ үед Үндэсний давхар даатгал ХК нь андеррайтингийн орлогоо нэмэгдүүлж, нөөц сангуудыг хангалттай хэмжээнд хүргэх шаардлага үүслээ. Үүний тулд гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэн зах зээлд эзлэх байр сууриа тэлнэ.

Түүнчлэн Үндэсний давхар даатгал ХК-ийн хүний нөөц, тэдний ур чадвар нь хөрөнгө оруулалтын эх үүсвэр, давхар даатгалын үйлчилгээг амжилтад хүргэх чухал хүчин зүйл байна. Манай компанийн ажилтнууд нь байгууллагын үнэт зүйлс, алсын хараа, эрхэм зорилго, дотоод хүчин зүйлс, үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэргэжлийн болон ажлын өндөр ур чадвартай байх ба ажилтан бүрийн оролцоог эрхэмлэсэн бодлого, стратегийг үйл ажиллагаандаа дагана.

Хавсралт 1. Компани санхүүгийн чадавхын олон улсын үнэлгээ тогтоолгох

Олон улсын зэрэглэл тогтоогч топ байгууллагуудад Стандарт энд Пүүрс, Фич, Мүүдийс болон АМ Бест агентлагууд орж байгаа бөгөөд үүнээс АМ Бест агентлаг нь даатгалын салбарт тусгайлан анхаардаг тул тус агентлагийн гаргасан зэрэглэлийг бусад орны даатгагч, давхар даатгагчид шууд хүлээн зөвшөөрдөг байна. Одоогоор тус агентлаг 198 давхар даатгалын компанид зэрэглэл тогтоожээ. Компанийн харилцагч олон улсын давхар даатгалын компаниудын үнэлгээг сонирхвол дийлэнх нь А үнэлгээтэй топ зэрэглэлийн компаниуд байна.

Хүснэгт 19. Үндэсний давхар даатгал ХК-тай хамтрагч давхар даатгалын компаниуд

№	Давхар даатгагч	Стандарт энд Пүүрс	Фич	Мүүдийс	АМ Бест
1	Свисс Ре	AA-, сөрөг		Аа3, тогтвортой	А+, тогтвортой
2	СКОР	AA-, тогтвортой	AA-, тогтвортой	Аа3, сөрөг	А+, тогтвортой
3	Тайпинг Ре		А, тогтвортой		А, тогтвортой
4	Жи Ай Си Ре				В++, тогтвортой
5	Ханновер Ре	AA-, тогтвортой			А+, тогтвортой
6	Пийк Ре			А3, тогтвортой	А-, тогтвортой

АМ Бест агентлаг аливаа аж ахуйн нэгжид зэрэглэл тогтоохдоо бизнес төлөвлөгөө, байгууллагын эрсдэлийн удирдлага болон гүйцэтгэлийн үйл ажиллагаанд шинжилгээ хийдэг. Зэрэглэл тогтооход удирдлагын баг, стратегийн зорилт, санхүүгийн байдал, үйл ажиллагааны менежмент, андеррайтингийн бодлого, нөөц сан, хөрөнгө оруулалт, нөхөн төлбөр, хохирол үнэлгээний бодлого зэрэг нь хамгийн чухал шалгуурт тооцогддог байна. Хүснэгт 18 -т компанийн одоогийн нөхцөл байдал болон зэрэглэл тогтоолгоход бэлтгэн хийж хэрэгжүүлэх ажлыг тоймлон харуулав.

Хүснэгт 20. Нөхцөл байдал, хийх ажлын хураангуй

	Одоогийн нөхцөл байдал	Хийж хэрэгжүүлэх ажил
Удирдлагын баг	Үндэсний давхар даатгал ХК нь Зураг 1-д харуулсан схемээр үйл ажиллагаагаа явуулж байна. Компанийн ТУЗ-ийн гишүүд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.1-т заасан төлөөллөөс /СЯ, ХХААХҮЯ, ҮСХ, Даатгалын холбооноос төлөөлөл/ бүрддэг.	Олон улсын нэр хүнд бүхий давхар даатгагчдын жишгийг үзвэл ТУЗ-ийн гишүүдээ даатгал, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр олон жил ажилласан туршлагатай гишүүдээр бүрдүүлдэг тул ТУЗ-ийн хараат бус төлөөллийг даатгал, актуар, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр ажлын туршлагатай гишүүдийг сонгох нь олон улсын стандартад нийцэхээр харагдаж байна.
Андеррайтингийн журам, андеррайтингийн орлого	Гүйцэтгэх захирлын 2020 оны А/24 тоот тушаалаар Андеррайтингийн журмыг баталсан.	Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсны дараа компанийн Андеррайтингийн журмыг илүү боловсронгуй болгох.
Эрх зүйн баримт бичгүүд	Компанийн зүгээс хууль болон зохицуулагч байгууллагаас гаргасан багц	Хууль, эрх зүйн шинэчлэлттэй уялдуулан тухай бүрт шаардлагатай журмуудад нэмэлт, өөрчлөлт хийх.

Санхүүгийн тайлан	дүрмийг өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллаж байна. Компани нь улирал бүр санхүүгийн тайлан гаргаж нийтэд зарладаг, мөн улирал бүр СЗХ-д тайлангаа хүргүүлж байна. Мөн сүүлийн 3 жил олон улсад нэр хүнд бүхий аудитын компаниар санхүүгийн тайландаа хяналт оруулж байгаа.	Компанийн санхүүгийн тайланд санхүүгийн шинжилгээ хийж тодорхой харьцаанууд зохимжит түвшинд байгаа эсэх, зорилтот түвшинд хүрэхийн тулд хэрхэн ажиллах талаар дүгнэлтийг тогтмол хийж, мөрдлөг болгон ажиллах.
Хохирол үнэлгээ, нөөц сангийн тайлан	Компанийн актуарч СЗХ-оос актуарчийн тусгай зөвшөөрөл авсан ба улирал бүр СЗХ-нд холбогдох журамд заасны дагуу нөөц сан болон төлбөрийн чадварын тайланг хүргүүлдэг.	
Эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээ	СЗХ-оос эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжих ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд даатгагч өөрийн эрсдэл ба төлбөрийн чадвараа үнэлэх зааврыг боловсруулан туршилтаар хэрэгжүүлж эхэлсэн ба Үндэсний давхар даатгал ХК-ийн зүгээс 2019, 2020, 2021 онд тус тайланг СЗХ-оос гаргасан аргачлалын дагуу бэлтгэн хүргүүлсэн.	"Эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлал"-ыг өргөжүүлэн, даатгалын эрсдэл дээр нэмээд хураамжийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлийг хэрхэн үнэлэх талаар тусгах бөгөөд энэхүү үнэлгээ нь зохицуулагч байгууллагын заавар, арга аргачлал, журмын дагуу хийгдэж, жилд 2 удаа "Өөрийн эрсдэлд суурилсан төлбөрийн чадварын харьцаа"-г тооцоолон зохистой түвшинд байгаа эсэхийг шалгаж ажиллах.
Хөрөнгө оруулалтын удирдамж	Компаниас хууль, Даатгалын багц дүрэм, холбогдох журмын дагуу компанийн хөрөнгийг тодорхой сувгуудад байршуулан ажилладаг.	

Хавсралт 2. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ

Даатгагчийн баталгаа

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тодорхой босгоос дээш төсөвтэй тендерт оролцогчид болон тендерт шалгарсан иргэд, ААН-дээс тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа, зарим тендерт урьдчилгаа төлбөрийн баталгаа, чанарын баталгааг шаарддаг. Тэгвэл Даатгалын тухай хуульд 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсоноор даатгагчид даатгагчийн баталгааг гаргах эрх зүйн чадамжтай болсон. Тус хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Үндэсний давхар даатгал ХК нь бусад даатгалын компаниудтай хамтран даатгагчийн баталгааны бүтээгдэхүүнийг боловсруулж байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2021 онд нийт 27,951 /ажил – 8287, бараа – 17276, зөвлөх үйлчилгээ – 1634, зөвлөхөөс бусад үйлчилгээ – 751, концесс – 3/ худалдан авах ажиллагааны жагсаалт орсон байна.

Үүнийг тендер шалгаруулалтын төрлөөр авч үзвэл:

- Бараа – 53.63 хувь буюу 11,781,153,493,367.74₮
- Ажил – 42.82 хувь буюу 9,406,235,797,603.22₮
- Зөвлөх үйлчилгээ – 2.04 хувь буюу 447,505,674,400₮
- Зөвлөхөөс бусад үйлчилгээ – 1.51 хувь буюу 331,845,589,091₮ байна.

Нийт худалдан авах ажлын захиалгад тендерийн баталгаа болон гүйцэтгэлийн баталгаа шаардах ажлуудыг нэгтгэн жагсааж, баталгаа шаардах дүнг тендерт оролцогч нь захиалагч талын төсөвт өртгөөс 20 хувь бууруулж санал өгдөг гэж тооцоолол хийв. Хуулийн дагуу дор хаяж 3 оролцогч санал өгч байж тендер хүчинтэй болдог тул тендерийн баталгаа шаардах босго давсан тендерийн тоог оролцох доод хэмжээгээр тооцож нийт дүнг гаргалаа. Гүйцэтгэлийн баталгааг зөвхөн тендерт шалгарсан этгээдээс шаардана.

Хүснэгт 21. Баталгаа шаардах тендерийн зах зээлийн тойм дүн /тэрбум төгрөг/

Тендерийн төрөл	Нийт төсөвт өртөг ₮	Босго давсан нийт төсөвт өртөг ₮	Тендерийн тоо	Оролцогчдоос ирүүлэх үнэ ₮	ТБ₮ 1%	Нийт ТБ₮ /дор хаяж 3/	ГБ₮ 5%
Бараа	3,502.43	3,344.54	4737	2,675.63	33.45	100.34	133.78
Ажил	7,483.17	7,355.91	2504	5,884.73	73.56	220.68	294.24
Зөвлөх	344.99	306.12	419	244.90	3.06	7.35	
Зөвлөхөөс бусад	132.79	125.55	249	100.44	1.26	3.01	
Нийт			7,909	8,905.70	111.32	287.24	524.33

Дээрх хүснэгтээс харвал тендерийн баталгаа шаардах зах зээлийн хамгийн доод эрэлт 287.24 тэрбум, гүйцэтгэлийн баталгаа шаардах доод эрэлт хэрэгцээ 524.33 тэрбум төгрөг байна.

Үндэсний давхар даатгал ХК-ийн боловсруулж буй даатгагчийн баталгааг банканд барьцаа хөрөнгө адил байршуулан баталгаа гаргуулах замаар ашиглах ба банкны


бүтээгдэхүүнийг орлох өөр санхүүгийн үйлчилгээ хайж буй ААН-үүд, мөн банканд баталгаа гаргуулахаар түгжигдсэн мөнгөө чөлөөлөн эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэн ашиглахыг хүссэн ЖДҮ эрхлэгчид, аливаа тендерт оролцон үйл ажиллагаагаа тэлэхийг хүссэн компаниуд ашиглах боломжтойгоороо давуу талтай юм. Эх үүсвэргүй баталгаа шаардагдах үед зээл судлах хугацаа хэт удаан байх, мөн банкны тавьсан өндөр шаардлагыг хангах боломжгүй үед уг даатгал хийлгэн ЖДҮ эрхлэгчид тендерт оролцох боломжтой болно.

Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн даатгал

Монгол Улсын Засгийн газраас баталсан Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт “Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх” гэж заасны дагуу “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д зээлийн урьдчилгаа төлбөрийг 20 хувь болгон бууруулж өөрчлөлт оруулсан ба иргэд 20 хувийн санхүүжилтээ бүрдүүлээд зээл авах боломжтой болсон. Үндэсний давхар даатгал ХК уг хөтөлбөрт нийцүүлэн Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн даатгалыг боловсруулан зах зээлд нийлүүлнэ.

Монголбанк, Засгийн газар болон банкуудын эх үүсвэрээр ипотекийн зээлийн хөтөлбөр 2013 онд хэрэгжиж эхэлснээс хойш 2021 оны эхний хагас жилийг дуустал нийт 5.6 их наяд төгрөгийн ипотекийн зээлийг 97.1 мянган зээлдэгчид олгосон байна. Цаашид Монголбанкнаас орон сууцны ипотекийн хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлж буй эерэг нөлөөллийг харгалзан үзэж хөтөлбөрийг урт хугацаанд, тогтвортой хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэхээр холбогдох байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн санхүүжилт 2024 он хүртэл тасралтгүй үргэлжлэх болно гэж мэдээлсэн.

График 19. Орон сууцны ипотекийн зээлийн нийт санхүүжилт /тэрбум төгрөг/



Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн даатгал нь зээлдэгч ипотекийн зээлээ төлөх боломжгүй болсон тохиолдолд банк, санхүүгийн байгууллагад даатгалаар хүлээсэн хариуцлагын хэмжээгээр нөхөн төлбөр олгодог даатгал юм. Уг даатгал нь зээл болон орон сууцны үнэлгээний харьцаанд үндэслэн даатгалын үнэлгээ, даатгал үргэлжлэх хугацааг тогтоодог бөгөөд уг зээл болон үнэлгээний харьцаа 80 хувиас дээш байвал зээлдэгч иргэн

тус даатгалд хамрагдах ёстой болно. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д зааснаар зээлдэгч урьдчилгаа төлбөрийн 10 хүртэл хувийг даатгуулах боломжтой бөгөөд сар бүр төлөх зээлийн эргэн төлөлт дээр даатгалын хураамжийг давхар төлөх замаар даатгалд хамрагдан орон сууцанд орох боломжтой.

Монголбанкны эх үүсвэрээр нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ 100 сая төгрөгөөс дээшгүй байдаг ба ипотекийн зээл 99 хувийн чанартай зээл гэж үздэг байна.

Гамшгийн даатгал

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2.5-д аливаа хуулийн этгээд “гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийн бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах” гэж заасан, мөн “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх” техник туслалцааны төслийн хүрээнд Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хууль боловсруулж байгаа ба уг хууль эрх зүйн хүрээнд иргэд, ААН, олон нийтийг байгалийн гамшигт үзэгдлээс хамгаалах даатгалын бүтээгдэхүүн боловсруулах эрэлт хэрэгцээ үүссэн.

Монгол Улсын нутаг дэвсгэр нь Төв Азийн газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд оршдог, судлаачдын боловсруулсан “Монголын газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зураг”- т нийт нутаг дэвсгэрийн 75 хувь нь 7 ба түүнээс дээш (М5К-) баллын бүс нутагт газар хөдлөлт болох магадлалтай болохыг тогтоожээ. Долоо ба түүнээс дээш балл бүхий газар хөдлөлтийн бүс нутагт нийт хүн амын 80 шахам хувь нь амьдарч байна.

Түүнчлэн борлуулагдаж буй үл хөдлөх хөрөнгийн даатгалд газар хөдлөлтийн хамгаалалт ихэвчлэн хасалтад байдаг бөгөөд томоохон ААН, байгууллага, онцгой объектуудад газар хөдлөлтийн даатгалын эрэлт хэрэгцээ өндөр байдаг. Уг эрэлтэд нийцүүлэн газар хөдлөлтийн параметрийн даатгалыг боловсруулж байна. Тус даатгал нь ард иргэдийн амьдралын баталгааг хамгаалах, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг хэвийн хадгалах зорилгоор газар хөдлөлтийн эрсдэл учирсан тохиолдолд хөрөнгөд учирсан бодит хохирлоор бус, тухайн газар хөдлөлтийн чичирхийлэлд өртсөн даатгалын байршилд Меркаллийн чичирхийллийн эрчим дээр суурилж богино хугацаанд нөхөн төлбөрийг даатгуулагчдад олгодог гамшгийн даатгалын нэг хэлбэр юм.

Бусад шинэ бүтээгдэхүүн

Үндэсний давхар даатгал ХК нь Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Экспортыг дэмжих төслийн хүрээнд Экспортын зээлийн даатгалыг боловсруулсан бөгөөд тус бүтээгдэхүүнийг экспортлогч ААН, ЖДҮ эрхлэгчдэд таниулан, зах зээлд нэвтрүүлнэ. Дэлгэрэнгүй төлөвлөгөөг V дугаар бүлэгт оруулав.

Ковид-19 цар тахлаас үүдэн иргэд эрүүл мэнд, амь насны даатгалд хамрагдах нь их болсон бөгөөд компани 2021 онд Хүнд өвчний даатгалыг СЗХ-нд бүртгүүлэн зах зээлд нэвтрүүлсэн. Үүнтэй уялдуулан 2022-2024 онд Монгол Улсад эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлдэг, чадамжтай компаниудын багцыг нэгтгэн олон улсын давхар даатгагч руу шилжүүлж, зах зээлд эрэлттэй байгаа эрүүл мэнд, эмчилгээний даатгалыг илүү хүртээмжтэйгээр борлуулна.

Мөн зах зээлийн хэрэгцээг мэдэрч дижитал, технологийн чиг хандлагад нийцүүлэн шинэ бүтээгдэхүүн боловсруулах, даатгалын салбарт шинээр нэвтэрч байгаа төрөл бүрийн

иншуртек /insurtech/ стартапууд эсвэл дижитал шийдлүүдийг санал болгодог компаниудтай холбогдож даатгалын шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээл дээр хөгжүүлэх, өөрийн бизнесийг өргөжүүлэх боломжтой.

Хавсралт 3. Гамшгийн бондын тухай

Гамшгийн бондын бүтэц

Зураг 2. Гамшгийн бондын үйл ажиллагааны схем



Гамшгийн бонд гаргахад тавигдах шалгуур

Санхүүгийн зохицуулах хорооны шалгуур:

- Үүсгэн байгуулагдаад гурван жил болсон, сүүлийн хоёр жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх,
- Хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх,
- Бондын үнийн дүнгээс багагүй өөрийн хөрөнгөтэй байх,
- Бонд гаргагч нь батлан даагчтай бол бонд гаргагч болон түүний батлан даагчийн өөрийн хөрөнгийн нийлбэр дүн нь бондын үнийн дүнгээс багагүй байх,
- Андеррайтерийн компанитай гэрээ байгуулсан байх,

Монголын хөрөнгийн биржийн шалгуур:

Шалгуур 1

- Тухайн чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх,
- Сүүлийн жилийн борлуулалтын орлогын хэмжээ 5.0 тэрбумаас дээш,
- Сүүлийн жилийн ашгийн хэмжээ 1.0 тэрбумаас дээш,
- Хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх,
- Андеррайтерийн компанитай гэрээ байгуулсан байх,

Шалгуур 2 /аль 1 шаардлагыг хангах/

- Санхүүжилт татах бондын үнийн дүн болон хүүгийн төлбөртэй тэнцэх барьцаа хөрөнгөтэй байх,
- Бондын эргэн төлөлтөд Засгийн газар баталгаа гаргасан байх,

- Олон улсын болон дотоодын зөвшөөрөгдсөн зээлжих зэрэглэл тогтоох байгууллагаас өндөр зэрэглэлтэй байх,

Гамшгийн бонд гарган татан төвлөрүүлэхэд шаардагдах өртөг

Гамшгийн бонд босгон татан төвлөрүүлэхэд шаардагдах зардал, шимтгэл дараах байдалтай байна.

Биржийн зах зээл дээрх шимтгэл:

- Санхүүгийн зохицуулах хорооны шимтгэл - 500.000 төгрөг,
- Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны хураамж,
 - Засгийн газар - 0.05%,
 - Компани - 0.1%,
- Зээлжих зэрэглэл тогтоолгох төлбөр,
- Андеррайтингийн үйлчилгээний хөлс – гэрээний дагуу тогтооно.

Биржийн бус зах зээл дээрх шимтгэл:

- Санхүүгийн зохицуулах хорооны шимтгэл - 500.000 төгрөг,
- Зээлжих зэрэглэл тогтоолгох төлбөр,
- Андеррайтингийн үйлчилгээний хөлс – гэрээний дагуу тогтооно.
- Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо – 2 сая төгрөг,
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв – 0.02 хувь (1-10 сая.төг)

Гамшгийн бонд татан төвлөрүүлэх арга зам

Гамшгийн бонд босгон татан төвлөрүүлэх боломжит 3 арга зам байна. Үүнд:

- Үндэсний давхар даатгал ХК нь зээлжих зэрэглэлээ тогтоолгон бонд гаргах,
- Монгол улсын Засгийн газраар баталгаа гаргуулах,
- Олон улсын байгууллагуудтай хамтрах:
 - Нэгдсэн үндэсний байгууллага,
 - Дэлхийн банк,
 - Азийн хөгжлийн банк,
- АНДЭЗНК (Ази номхон далайн эдийн засгийн нийгмийн комисс),
- Бусад Олон Улсын байгууллага.

Хавсралт 4. Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хариуцах газар нэгж	Хугацаа			
					2022	2023	2024	2025
ЗОРИЛГО. НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ								
Зорилт 1. Компанийн санхүүгийн чадаахын олон улсын үнэлгээ тогтоолох								
1.	ISO стандартыг нэвтрүүлэх	Компанийн андеррайтингийн бодлого, эрсдэлийн удирдлага, комплаесийн хэрэгжилтийг олон улсын жишигт нийцүүлэх.	ISO стандартыг нэвтрүүлсэн байна.	Бүх газар, нэгж		+		
2.	Олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагын аргачлалаар компанийн үнэлгээг хийх	Олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагуудаас судалгаа хийн тодорхойлж, тухайн байгууллагын аргачлалаар компанийн өөрийн үнэлгээг хийнэ	Компани өөрийгөө үнэлж, сайжруулах үйл ажиллагааны хэсгүүдийг тодорхойлсон байна.	Бизнес хөгжил, төслийн газар Эрсдэлийн удирдлага, хөрөнгийн менежментийн газар	+			
3.	Компанийн сайжруулах шаардлагатай үйл ажиллагааг шинэчлэх	Өөрийн үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн үйл ажиллагааг сайжруулах, шаардлагатай бол шинэчлэх	Компанийн бүх үйл ажиллагаа зэрэглэл тогтоолоход бэлэн болсон байна.	Бүх газар, нэгж	+	+	+	+
4.	Компанийн санхүүгийн чадавхын олон улсын үнэлгээ тогтоолох	Компани олон улсын тогтоогч зэрэглэл байгууллагаар зэрэглэл тогтоолох	Компани олон улсын зэрэглэлтэй байна.	Бүх газар, нэгж		+		
Зорилт 2. Компанийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх								
1.	Даатгалын үйл ажиллагаанд актуар шаардагдах тооцоолол хийх, актуар тайлан гаргах	Актуарын тооцооллын арга аргачлалыг хөгжүүлэх, түүнд ашиглагдах загварчлалыг боловсруулах, олон улсын стандартыг судлах	Актуарын тооцооллын арга аргачлалыг хөгжүүлэх, түүнд ашиглагдах загварчлалыг боловсруулах, олон улсын стандартыг судалсан байна.	Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар	+	+	+	+
2.	Байгууллагад учирч болзошгүй даатгалын бус эрсдэлүүдийг тодорхойлж, эрсдэлийн удирдлагын зохистой	Байгууллагад учирч болзошгүй даатгалын болон даатгалын бус эрсдэлүүдийг тодорхойлж, эрсдэлийн удирдлагын зохистой арга	Байгууллагад учирч болзошгүй даатгалын бус эрсдэлүүдийг тодорхойлж, эрсдэлийн удирдлагын зохистой	Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар	+	+	+	+

арга аргачлалуудыг ашиглан эрсдэлүүдийг илрүүлэх, танилцуулах, тайлагнах	аргачлалуудыг тухайн эрсдэлүүдийг үнэлэх	арга аргачлалуудыг ашиглан эрсдэлүүдийг үнэлэн тайлагнасан байна.	аргачлалуудыг тухайн эрсдэлүүдийг үнэлэн тайлагнасан байна.	+	+	+	+	+	+	+
	Даатгалын үндсэн үйл ажиллагааны эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийж, эрсдэлийн түвшин, индексүүдийг үнэлэх, тайлагнах, байгууллагын бүх нэгжийн хэмжээнд эрсдэлийн талаарх ойлголтыг таниулах	Даатгалын үндсэн үйл ажиллагааны эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийж, эрсдэлийн түвшин, индексүүдийг үнэлэх, тайлагнах, байгууллагын бүх нэгжийн хэмжээнд эрсдэлийн талаарх ойлголтыг таниулах	Даатгалын үндсэн үйл ажиллагааны эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийж, эрсдэлийн түвшин, индексүүдийг үнэлэх, тайлагнах, байгууллагын бүх нэгжийн хэмжээнд эрсдэлийн талаарх ойлголтыг таниулах	Эрсдэлийн удирдлагын стратегийн бодлогыг боловсруулах, ISO стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэх	Эрсдэлийн удирдлагын стратегийн бодлоготой болсон байна.	Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар	+	+	+	+
Зорилт 3. Комплаенсын хэрэгжилтийг хангах										
1.	Компанийн комплаенсын эрсдэлийг үнэлэх, хянах, дотоод дүрэм, журмуудыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн боловсруулж, биелэлтийг дүгнэх, үр нөлөөг судлах	Андеррайтингийн журам, Хөрөнгө зохицуулах журмын шинэчилсэн төсөл, Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг боловсруулж, батлуулах	Компанийн ажиллагаа холбогдох зааварт комплаенс эрсдэл шийдвэрлэгдсэн байна.	Компанийн үйл хууль, журам, нийцэж, эрсдэл шийдвэрлэгдсэн байна.	Комплаенс, нөхөн төлбөрийн газар	Комплаенс, нөхөн төлбөрийн газар	+	+	+	+
2.	Компанийн ТУЗ-ийн тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр, эрх зүйн актуудыг тогтоомжид нийцүүлэн хянах	ТУЗ-ийн тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр, эрх зүйн актуудыг хууль тогтоомжид нийцүүлэн хянах, удирдлагаас гарч буй шийдвэр тус бүр дээр загвар боловсруулах	Тогтоол, тушаал, эрх зүйн үндэслэл, найруулга холбогдох хууль, журамд нийцсэн байна.	Тогтоол, тушаал, эрх зүйн үндэслэл, найруулга холбогдох хууль, журамд нийцсэн байна.	Комплаенс, нөхөн төлбөрийн газар	Комплаенс, нөхөн төлбөрийн газар	+	+	+	+

3.	Компанийн бусад этгээдтэй байгуулах бүх төрлийн гэрээ, албан бичгийн төслийн эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянах	Компаниас бусад этгээдтэй байгуулах бүх төрлийн гэрээ, хэлцлийн төсөл боловсруулах, эрх зүйн үндэслэлийг хянах	Гэрээ, хэлцлийн эрх зүйн үндэслэл, найруулга холбогдох хууль, журамд нийцэж, компанийн гэрээнээс үүдэлтэй эрсдэл буурсан байна.	Компаниас бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулах албан тоотын төсөл боловсруулах, эрх зүйн үндэслэлийг хянах	Албан тоотын эрх зүйн үндэслэл, найруулга холбогдох хууль, журамд нийцэж, компанийн бусад байгууллага, иргэнтэй харилцах харилцаа хэвийн явагдана.	Комплаенс, нөхөн төлбөрийн газар	+	+	+	+	+	+
Зорилт 4. Сайн засаглалын бүтэц, чиг үүргийг хэрэгжүүлэх												
1.	Компанийн үйл ажиллагаанд үр дүнтэй аудит шалгалтыг хийж гүйцэтгэх, засаглал, хяналтын үйл явцын үр ашиг, үр нөлөөг сайжруулах	Дотоод хяналтын нэгжийн бүтцийг боловсронгуй болгож, үйл ажиллагааг сайжруулах	Засаглалын сайн тогтолцоотой болсон байна.	Дотоод хяналтын бүтэц, чиг үүргийг хэрэгжүүлэх	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо Дотоод хяналтын ажилтан	+	+	+	+	+	+	+
2.	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцсэн санхүү бүртгэлийн ажиллагааг тодорхой, шинэ түвшинд хүргэх	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх	Хуулийн шинэчлэлт өөрчлөлттэй холбоотойгоор бодлогын баримт бичгийн өөрчлөлтийг хийснээр байгууллагын цаашдын бүртгэл хөтлөлт зөв явагдах	Захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтэс	+	+	+	+	+	+	+	+
		Санхүүгийн албаны бүтэц өргөтгөж ажил үүргийн хуваарийг зөв зохион байгуулж бүртгэл хяналтыг сайжруулах	Ажил үүргийн хуваарийг зөв зохион байгуулснаар бүртгэл хяналт сайжирна.		+	+	+	+	+	+	+	+
		Компанийн худалдан авах ажиллагааг хариуцан ажиллах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журам, зааврын хэрэгжилтийг ханган ажилласан байна.		+	+	+	+	+	+	+	+
Зорилт 5. Боловсон хүчний чадахыг бэхжүүлэх												

1.	Компанийн нийт ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлж, хүний нөөцийн нэгдсэн төлөвлөгөө болон журам бодлого, боловсруулан нийцлийг хангаж, даатгалын чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх	Дотоод болон гадаад сургалтын төлөвлөгөөг гарган ажилтнуудаа чадавхжуулах сургалтад хамруулах	Гадаад, дотоод сургалтаар дамжуулан ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлж, чадварлаг хүний нөөцийг батийг бүрдүүлсэн байна.	Захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтэс	+	+	+	+	+	+
Зорилт 6. Нийгмийн харууцлагатай компани байх										
1.	Нийгмийн харууцлагатай компани болж нийгэмдээ үр өгөөжтэй, хүрээлэн буй орчиндоо эергээр нөлөөлөх ажлуудыг хэрэгжүүлэх	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэх	Мод тарих газрыг тодорхойлж, жил бүр тарьсан модоо арчилсан байна.	Бүх газар, нэгж	+	+	+	+	+	+
		Их сургуулиудын эрдэм шинжилгээний бага хуралд өөрсдийн сантай уралдаан зарлах	Жил бүр уламжлал болгон зарлаж, шалгаруулсан байна.	Ажлын хэсэг	+	+	+	+	+	+
		Бусад акц, хөдөлгөөнийг санаачлан хэрэгжүүлнэ.	Нийгэмд хэрэгцээтэй акц санаачлан бодит хувь нэмэр оруулсан байна.	Бүх газар, нэгж	+	+	+	+	+	+
		Цусаа хандивлах өдрийн товлон	Цусаа хандивласан байна	Бүх газар, нэгж	+	+	+	+	+	+
ЗОРИЛГО. ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРЛИЙГ ОЛШРУУЛЖ, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ										
Зорилт 1. Даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ										
1.	Далд уул уурхайн салбарын даатгалын эрэлт хэрэгцээг хангасан бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх	Даатгалын компани болон оролцогч талуудтай уулзах, газар дээр нь очиж, даатгалын эрэлт хэрэгцээ, зах зээлийг тодорхойлох	Даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг тодорхойлж, харилцагчдад санал болгосон байна.	Бизнес хөгжил, төслийн газар Андеррайтингийн газар	+	+	+	+	+	+
		Давхар даатгалын гэрээний төслийг бэлтгэх, зах зээлд нэвтрүүлэх	Зах зээлд нэвтэрсэн байна.		+	+	+	+	+	+
2.	Газрын тос, нефтийн бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлийг даатгах	Даатгалын компани болон оролцогч талуудтай уулзах, даатгалын эрэлт хэрэгцээ, зах зээлийг тодорхойлох	Даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг тодорхойлсон байна.	Бизнес хөгжил, төслийн газар Андеррайтингийн газар	+	+	+	+	+	+
		Давхар даатгалын гэрээний төслийг бэлтгэх, зах зээлд нэвтрүүлэх	Давхар даатгалын төсөл боловсруулагдсан байна		+	+	+	+	+	+

3.	Баталгааны даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх	Төрийн худалдан авах ажиллагаа тендэрт оролцож буй ААН-үүдийн судалгааг хийх, эрэлт хэрэгцээг тодорхойлох	Тендэрт оролцож буй ААН-үүдийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, хэрэгжүүлэх баталгааны даатгалын бүтээгдэхүүнээ тодорхой болгосон байна.	Туршлагатай хамтарч ажиллах даатгалын компани сонгож, зах зээлд нэвтэрсэн байна.	Бизнес хөгжил, төслийн газар Андеррайтингийн газар	+		+	+	+		
4.	Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх	Зах зээлийн судалгааг хийх, эрэлт хэрэгцээг тодорхойлох	Баталгааны даатгалд хамтран оролцох даатгалын компани сонгох, хамтын ажиллагаагаа эхлүүлэх, зах зээлд нэвтрүүлэх	Эрэлт хэрэгцээг тодорхойлж, хэрэгжүүлэх даатгалын бүтээгдэхүүнээ тодорхой болгосон байна.	Бизнес хөгжил, төслийн газар Андеррайтингийн газар	+						
5.	Гамшгийн даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх	Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн даатгалд хамтран оролцох даатгалын компани сонгох, хамтын ажиллагаагаа эхлүүлэх, зах зээлд нэвтрүүлэх	Гамшгийн даатгалын судалгааг хийх, эрэлт хэрэгцээг тодорхойлох	Туршлагатай хамтарч ажиллах даатгалын компани сонгож, зах зээлд нэвтэрсэн байна.	Бизнес хөгжил, төслийн газар Андеррайтингийн газар	+		+	+	+	+	+
6.	Бэлчээрийн даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх	Гамшгийн даатгалд хамтран оролцох даатгалын компани сонгох, хамтын ажиллагаагаа эхлүүлэх, зах зээлд нэвтрүүлэх	Холбогдох судалгааг хийх, эрэлт хэрэгцээг тодорхойлох	Эрэлт хэрэгцээг тодорхойлж, хэрэгжүүлэх даатгалын бүтээгдэхүүнээ тодорхой болгосон байна.	Бизнес хөгжил, төслийн газар Андеррайтингийн газар	+						
		Бэлчээрийн даатгалд хамтран оролцох даатгалын компани сонгох, хамтын ажиллагаагаа эхлүүлэх, зах зээлд нэвтрүүлэх	Эрэлт хэрэгцээг тодорхойлж, хэрэгжүүлэх даатгалын бүтээгдэхүүнээ тодорхой болгосон байна.	Туршлагатай хамтарч ажиллах даатгалын компани сонгож, зах зээлд нэвтэрсэн байна.	Бизнес хөгжил, төслийн газар Андеррайтингийн газар	+		+	+	+	+	+

7.	Итгэлцлийн даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх	Зах зээлийн судалгааг хийх, эрэлт хэрэгцээг тодорхойлох	Зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, хэрэгжүүлэх даатгалын бүтээгдэхүүнээ тодорхой болгосон байна.	Бизнес төслийн хөгжил, газар Андеррайтингийн газар	+				
8.	Бусад шинэ даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх судалгаа хийх	Итгэлцлийн даатгалд хамтран оролцох даатгалын компанийг сонгох, хамтын ажиллагаагаа эхлүүлэх, зах зээлд нэвтрүүлэх	Туршлагатай хамтарч ажиллах даатгалын компаниа сонгож, зах зээлд нэвтэрсэн байна	Бизнес төслийн хөгжил, газар Андеррайтингийн газар	+	+	+	+	+
Зорилт 2. Гаднын байгууллагын зээлийн андеррайтинг хийх									
1.	Зорилтот ААН-үүдэд бүтээгдэхүүн танилцуулах	Экспортлогч, мөн гадаад худалдаа хийх зорилготой ААН-үүдэд бүтээгдэхүүнийг танилцуулах	Хамтран ажилласан байна.	Бизнес төслийн хөгжил, газар	+	+	+	+	+
2.	Санхүүгийн андеррайтинг хийх	Тинүбү Сүжэр групптэй хамтран уг үйлчилгээг нэвтрүүлэх	ААН-үүдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	Бүх газар, нэгж	+	+	+	+	+
Зорилт 3. Олон улсын зах зээлд давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх									
1.	Азийн зах зээлд давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх	Давхар даатгалын брокер болон давхар даатгагчид сонирхолоо илэрхийлэх, тэднээс ирсэн саналд тооцоолол хийх	Гэрээ хийсэн байна.	Андеррайтингийн газар Бизнес хөгжил, төслийн газар		+	+		+
Зорилт 4. Гамшгийн бонд гаргах, удирдах									
1.	Гамшгийн бонд гаргах	Гамшгийн бонд гаргах бүтэц, шалгуурыг тодорхойлох.	Шалгуур үзүүлэлтүүдийг хангасан, бүтэц схемээ тодорхойлсон байна.	Ажлын хэсэг		+			
		Гамшгийн бонд татан төвлөрүүлэхэд хамран ажиллах талуудад санал тавих	Хамтран ажиллах боломжтой талуудад саналаа танилцуулсан байна.	Ажлын хэсэг		+	+		+
		Гамшгийн бонд гаргах	Бонд гаргасан байна.	Ажлын хэсэг			+	+	+
ЗОРИЛГО. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ									
Зорилт 1. Гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлэх									
1.	Хамтран ажиллах давхар даатгалын компаниуд, зуучлагч нарыг тодорхойлж, харилцаа тогтоох	Азийн давхар даатгалын холбооны гишүүн орнууд болон олон улсын топ зэрэглэлийн хамтран ажиллах давхар даатгалын	Хамтран ажиллах давхар даатгалын компаниуд, зуучлагч нарыг тодорхойлж, харилцаа тогтоосон байна.	Бизнес төслийн хөгжил, газар Андеррайтингийн газар	+	+	+		

[illegible]

	гаргаж, цуглуулах	мэдээлэл	ЗОРИЛГО. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ									
			Санал өгсөн байна.	Комплаенс, нөхөн төлбөрийн газар	+	+	+	+	+	+	+	+
1.	Холбогдох хуулиудад санал өгч ажиллах	Хуулийн төслийн ажлын хэсэгт орж ажиллах, хуулийн төсөлд компанийн үйл ажиллагаа, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр ач холбогдолтой зохицуулалт тусуулах талаар ажлын хэсэгтэй нягт хамтран ажиллах	Хуулиуд батлуулсан байна.	Комплаенс, нөхөн төлбөрийн газар	+	+	+	+	+	+	+	+
2.	Даатгалын багц дүрэмд нийцүүлэн шинэчлэх, гаргах журмуудыг боловсруулж, батлуулах	Шинэчлэх, боловсруулан шаардлагатай журмуудын жагсаалтыг гаргаж, төслийг боловсруулан холбогдох этгээдээр батлуулах	Журмууд батлуулсан байна.	Комплаенс, нөхөн төлбөрийн газар	+	+	+	+	+	+	+	+